



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

# ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХЭРХЭН АВАХ ВЭ?

Иргэдэд зориулсан гарын авлага

*Улаанбаатар хот  
2006 он*

DDC  
345.052'023  
T-727

**Зохиогчид:**

Н. Туяа  
Д. Ганзориг  
Р. Энхтүвшин  
Ц. Давхарбаяр  
Ж. Эрдэнэбулган

**Хянан тохиолдуулсан:**

С. Нарангэрэл, Академич  
Ж. Баярцэцэг  
Д. Батжаргал

**Хэвлэлд бэлтгэсэн:**

Д.Батболд  
Г.Батчимэг

**Хаяг:** *Жамъян Гүний гудамж-5/1  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48  
Монгол улс  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб хуудас: [www.forum.mn](http://www.forum.mn)*

*Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл  
Нээлттэй Нийгэм Форум хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.*

**ISBN 99929-90-44-9**

*Эхийг “СОДПРЕСС” ХХК-д бэлтгэж хэвлэв.*

**ГАРЧИГ**

<b>Өмнөх үг</b>	<b>5</b>
<b>Бүлэг 1. Таны өмгөөлүүлэх эрх</b>	
1.1. Өмгөөлүүлэх эрхээ хэрхэн эдлэх вэ?	6
1.2. Эрүүгийн хэрэг ба өмгөөлүүлэх эрх	15
1.3. Иргэний маргаан ба өмгөөлүүлэх эрх	23
1.4. Захиргааны хэрэг ба өмгөөлүүлэх эрх	42
1.5. Өмгөөлүүлэх эрхийг хангах эрх зүйн зохицуулалт	58
<b>Бүлэг 2. Та төлбөрийн чадваргүй бол хууль зүйн туслалцаа хэрхэн авах вэ?</b>	<b>63</b>
2.1. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх төрөөс санхүүжүүлсэн өмгөөллийн туслалцаа	64
2.2. Өмгөөлөгчдийн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа	71
2.3. Төлбөрийн чадваргүй иргэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах бусад боломж	81
<b>Бүлэг 3. Хууль зүйн туслалцаа авах бусад боломжууд</b>	<b>87</b>
3.1. Төрийн байгууллагаас авах хууль зүйн мэдээлэл болон өргөдөл гомдлоо хэрхэн шийдвэрлэх вэ?	88
3.2. Хууль зүйн Клиникээс үзүүлэх хууль зүйн туслалцаа	95
3.3. Төрийн бус байгууллагуудаас үзүүлэх хууль зүйн туслалцаа	104
3.4. Хууль зүйн туслалцаа үзүүлэх шинэлэг хэлбэрүүд	109
<b>Товчилсон үгийн жагсаалт</b>	
1. ИХШХШТХ- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	
2. ЭБШТХ - Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль	
3. ЭБША - Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа	
4. ХЗДХЯ - Хууль зүй дотоод хэргийн яам	
5. ЭБШХ - Эрүүгийн байцаан шийтгэх хууль	
6. УТХ - Улсын тэмдэгтийн хураамж	
7. УДШ - Улсын Дээд шүүх	
8. СБД - Сүхбаатар дүүрэг	
9. БЗД - Баян-Зүрх дүүрэг	
10. БГД - Баянгол дүүрэг	
11. ХЗДС - Хууль зүйн дээд сургууль	

## ИРГЭН ТАНЫГ ХӨТЛӨХИЙН УЧИР

Нээлттэй Нийгэм Форумгаас иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдэд зориулсан цуврал хөтөч бэлтгэн гаргаж байгаа билээ. Энэхүү хөтөчийн нэг болох “Хууль зүйн туслалцаа хэрхэн авах вэ” гарын авлага нь та бүхний гар дээр очиж байна.

Энэхүү гарын авлага нь өмгөөллийн үйлчилгээний асуудлаар иргэдэд чухал шаардлагатай мэдээллийг хялбаршуулсан хэлбэрээр хүргэн улмаар иргэдийн өмгөөлүүлэх болон төлбөрийн чадваргүй иргэдийн үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа авах эрхээ эдлэхэд хөтөч болох зорилготой.

Гарын авлагад төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжтой өмгөөлөгчдийн жагсаалт болон эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагуудын лавлагаа танилцуулгыг багтаасан болно.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж уг гарын авлагыг боловсруулсан МУИС-ын Хууль Зүйн Дээд Сургуулийн “Хүмүүнлэг” хууль зүйн клиникийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал



1

# БҮЛЭГ 1

## ТАНЫ ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХ

- 1.1. Өмгөөлүүлэх эрхээ хэрхэн эдлэх вэ?
- 1.2. Эрүүгийн хэрэг ба өмгөөлүүлэх эрх
- 1.3. Иргэний маргаан ба өмгөөлүүлэх эрх
- 1.4. Захиргааны хэрэг ба өмгөөлүүлэх эрх
- 1.5. Өмгөөлүүлэх эрхийг хангах эрх зүйн зохицуулалт

Та энэхүү бүлгээс өмгөөлүүлэх эрх, түүнийг хангах хууль, дүрэм, журамтай танилцаж тодорхой хэрэг маргааны үед хууль зүйн туслалцаа хэрхэн авах, өөрийгөө өмгөөлөх, мэргэжлийн өмгөөлөгч сонгон авах боломжууд, өмгөөлөгчийн эрх, хүлээх үүргийн тухай мэдэх болно.

## 1.1. ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХЭЭ ХЭРХЭН ЭДЛЭХ ВЭ?

Өмгөөлүүлэх эрх гэдгийг зөвхөн өмгөөлөгч сонгон авах, өмгөөлөгчтэй байх мэтээр ихэвчлэн ойлгодог. Таны өмгөөлүүлэх эрх илүү өргөн цар хүрээтэй байдаг.

Өмгөөлүүлэх эрх нь дараах гурван хэлбэртэй байдаг.

- ◆ Өөрийгөө өмгөөлөх
- ◆ Өмгөөлөгч авах
- ◆ Эрхээ хэрэгжүүлэх боломж нөхцлөөр хангагдах.

### ӨӨРИЙГӨӨ ӨМГӨӨЛӨХ ЭРХ

Өөрийгөө өмгөөлөх эрх нь дараах хэлбэрээр илэрнэ.

1. Мэдээлэл авах
2. Хүсэлт гаргах
3. Гомдол гаргах
4. Тайлбар гаргах
5. Тодорхой байцаан шийтгэх ажиллагаанд биечлэн оролцох. Эдгээрийг хуульд заасан арга хэрэгсэл хэмээн үздэг.

**1. Мэдээлэл авах гэдэг нь:** Ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа асууж мэдэх, шинжээч томилсон томилоттой болон нэгжлэг, үзлэг хийх, хураан авах тогтоолтой танилцах эрхтэй. Мөн ямар хэрэгт гэрчээр дуудсан болохыг мэдэх, гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч нар байцаалт, тэмдэглэлийг уншиж танилцаад нэмэлт, өөрчлөлт оруулах, засвар хийх зэргээр өөрийн идэвхитэй үйлдлээр ашигтай байдлыг бий болгохыг хэлнэ.

**2. Гомдол, хүсэлт гаргах гэдэг нь:** Тодорхой хүнийг гэрчээр байцаах, байцаан шийтгэх ажиллагаа хийлгэх (давтан шинжилгээ хийлгэх, туршилт хийлгэх, мэдүүлгийг газар дээр нь шалгуулах, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах гэх мэт) хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх болон шүүгчид гаргах замаар өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахыг хэлнэ.

**3. Тодорхой байцаан шийтгэх ажиллагаанд биечлэн оролцох гэдэг нь:** Сэжигтэн яллагдагч нь мэдүүлэг өгөх, түүнээс татгалзах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох ба энэ талаар илүү дэлгэрэнгүйг 1, 2 дахь хэсгээс үзнэ үү.

### ӨМГӨӨЛӨГЧ АВАХ ЭРХ

Та бидний амьдарч буй зах зээлийн чөлөөт нийгэмд амьдралын гол чухал асуудлууд хуулиар зохицуулагддаг. Олон янзын хууль үйлчилж, гарцыг нь олоход нэн төвөгтэй хэрэг маргаантай тулгарч, мэргэжлийн хуульчаас туслалцаа хүсэхээс өөр аргагүй байдалд оруулдаг нь бий.

Мэргэжлийн хуульч гэхээр шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, өмгөөлөгч гэх мэт олон янз. Тэднээс мэргэжлийн туслалцаа үзүүлж, таны өмнөөс хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүргийг хүлээдэг нь өмгөөлөгч юм.

Өмгөөлөгч нь хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн сонгон шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэн байна. Мөн монгол хэл мэддэг харъяалалгүй хүн, гадаадын иргэн хуульч Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа явуулахыг хүсвэл мэргэшлийн шалгалт өгсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл авч явуулна. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг мэргэшлийн шалгаруулалтад тэнцсэн хуульчид олгох асуудлыг мэргэжлийн болон сахилгын хорооны саналыг үндэслэн Хууль зүй дотоод хэргийн сайд шийдвэрлэдэг.



Өмгөөлөгч заавал авах шаардлага нь талуудын тэгш байдлыг хангах өөрөөр хэлбэл, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, иргэдийн төлөөлөгч нөгөө талаас, өөрийн болон төлөөлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалан оролцогч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нарын тэгш байдлыг хангах зорилготой. Төрийн байгууллага, албан тушаалтан давуу эрх эдлэх, хүчээр түрэмгийлэх, яллах талыг баримтлах гажуудалд хүргэхгүйн тулд өмгөөлөгчийн оролцоог баталгаажуулж хуульчилсан байна. Ийнхүү яллах, өмгөөлөх талуудын мэтгэлцээний дүнд тухайн гэмт хэргийн талаархи бодит үнэнийг тогтоох боломж бүрдэнэ.

**Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхэд нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцож үл болно.**

*/ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-дэх хэсэг /*

Үндсэн хуулийн энэхүү зарчмыг эрүүгийн гэмт хэргийг шалгах, мөрдөн байцаах, шүүхээр хянан шийдвэрлэх бүх үе шатанд баримтлана. Энэ зарчмын гол агуулга нь шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд гэмт хэрэгт холбогдсон этгээдийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал түүнд ашигтайгаар шийдвэрлэж болно. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруутай эсэхэд, түүнчлэн Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал тэдгээрт ашигтайгаар буюу үйлдлийг нь хэрэгсэхгүй болгох, хөнгөн зүйл ангиар солих, цагаатгах тогтоол гаргах боломжтой. Ийм учраас өмгөөлөгчийн туслалцаа авах нь зайлшгүй чухал бөгөөд энэ байдлыг харгалзан үзээд төрөөс тодорхой хэмжээний төсөв мөнгийг төлбөрийн чадваргүй хүмүүст өмгөөллийн туслалцаа үзүүлэхэд зориулан төсөвлөдөг байна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хоёрдугаар бүлгээс үзнэ үү.

Өмгөөллийн үйл ажиллагааг зөвхөн эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаанд өмгөөлөх тал болон оролцох мэт явцууруулан үзэж болохгүй. Учир нь өмгөөллийн үйл ажиллагаа нь дараах хэлбэртэй байна. Үүнд:



- ◆ Хуулийн заалтын талаар амаар болон бичгээр лавлагаа өгөх
- ◆ Хууль зүйн асуудлаар зөвлөгөө өгөх
- ◆ Өргөдөл, гомдол, нэхэмжлэл, мөн бүх төрлийн гэрээний эх зохиож өгөх
- ◆ Шүүх болон бусад байгууллагад үйлчлүүлэгчээ төлөөлөн оролцох
- ◆ Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхээр хэлэлцэх шатанд өмгөөлөгчөөр оролцох

Өмгөөллийн туслалцаа үзүүлэх эдгээр хэлбэр эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэхэд ямар онцлогтой болохыг 1.2, 1.3, 1.4 дэх хэсгүүдээс үзнэ үү.

Өмгөөлөгч нь шүүхэд үйлчлүүлэгчээ төлөөлөн оролцох, хэлэлцэх шатанд өмгөөлөн оролцдог. Монгол улсын шүүхийн тогтолцоо нь дараах бүтэцтэй.



**Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.**

(Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 8 дугаар зүйл.)

Өмгөөлөгчийг дараах хэлбэрээр сонгон авч болно.

1. Өөрөө сонгон авах
2. Гэмт хэрэгт холбогдсон хүний зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн сонгох.
3. Сонгож авах боломжгүй бол өмгөөлөгч томилуулах

Өмгөөлөгчөө сонгох нь гэмт хэрэгт холбогдсон этгээдийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр, түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүнд зайлшгүй хамаатай асуудал юм. Өөрөөр хэлбэл, тэд сайн дурын үндсэн дээр, ямар нэг шахалт, дарамтгүйгээр өмгөөлөгчөө сонгоно гэсэн үг юм.

МӨХ болон аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн салбар зөвлөл дээр очиж өмгөөлөгчдийн нэр, хаяг, мэргэшсэн чиглэлийн талаарх лавлагаатай танилцсаны дараа сонголтоо хийх нь зүйтэй. Сонголт хийхдээ тухайн өмгөөлөгчийн ажилласан жил, туршлага, ямар төрлийн гэмт хэргийг дагнан өмгөөлдөг болохыг судлах нь чухал.

Хүмүүс зөвхөн нэг өмгөөлөгчтэй байх мэтээр ерөнхийлөн ойлгох нь элбэг тохиолддог. Гэвч 2002 онд батлагдсан ЭБШ хуульд нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болохыг зөвшөөрсөн байна.

Мөрдөн байцаалт шүүхийн практикаас үзэхэд ЭБША-ны явцад хэд хэдэн өмгөөлөгч сонгон авч байна. Жишээ нь, шүүхийн өмнөх шатанд авсан өмгөөлөгч нь байцаалт болон мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаанд оролцох, нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаанд гомдол гаргах тэднийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах, хавтаст хэргийн материалтай танилцаж санал хүсэлт гаргах талаар хууль зүйн туслалцаа үзүүлдэг бол шүүхэд шилжсэн үеэс сонгон авсан өмгөөлөгч нь цугларсан нотлох баримтад дүн шинжилгээ хийж шүүхэд мэтгэлцэх байр сууриа тодорхойлж бүх шатны шүүхэд эрхийг нь хамгаалж оролцдог байна. Түүнээс гадна сүүлийн үед олон холбогдогчтой томоохон хэрэг дээр өмгөөлөгч нарын баг ажиллах хэлбэр нэвтэрч эхэллээ. Ийнхүү хэдэн өмгөөлөгч сонгох нь иргэн таны хүсэл зориг, төлбөрийн чадвараас шалтгаалах асуудал юм. Харин төлбөрийн чадваргүй тохиолдолд хаанаас өмгөөлөгч томилдог тухай II бүлгээс уншаарай.

Хэргийн талаар харилцан эсрэг саналтай хэд хэдэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг нэг өмгөөлөгч өмгөөлж болохгүй.



Сонгосон өмгөөлөгч таны эрх ашгийг төлөөлж чадахгүй гэж үзвэл өмгөөлөгчөөсөө татгалзах эрхтэй.

### **ӨМГӨӨЛӨГЧ ЗААВАЛ БАЙХ ТОХИОЛДОЛ**

Хуульд заасны дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч нь дараах тохиолдолд заавал өмгөөлөгчтэй байна.

- ◆ Хэлгүй, дүлий, хараагүй, сэтгэцийн өвчтэй байх
- ◆ Насанд хүрээгүй бол
- ◆ Монгол хэл мэддэггүй бол
- ◆ Цаазаар авах ялаар шийтгэгдэж болох

Хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол

бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь заавал өмгөөлөгч авч байхаар хуульчилсан байна. Ийнхүү өмгөөлөгч заавал оролцох тохиолдлуудыг тусгайлан авч үзсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, монгол хэл мэдэхгүй хүн, цаазаар авах ялтай гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг өмгөөлүүлэх эрхээр хангах, тэдний эрх ашгийг ямар нэг хэлбэрээр хохироохгүй байх зорилготой юм.

## ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ

Өмгөөлөгч нь хуульд заасан дараах эрх эдлэнэ.

- ◆ Хууль зүйн туслалцаа хүсэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аль ч байгууллагад төлөөлөх;
- ◆ Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдолтой тэдгээрийн байгаа газар чөлөөтэй нэвтрэн орж, ганцаарчлан уулзах.
- ◆ Эрүү, иргэний хэргийн нотлох баримттай танилцах, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өөрийн зардлаар хувилж хуулбарлан авах;
- ◆ Нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах санал хүсэлт тавих;

- ◆ Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа шийдвэрт гомдол гаргах;
- ◆ Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, иргэдийн төлөөлөгч, шүүх хурлын нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
- ◆ Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, болон хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд байлцаж, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч түүнчлэн нэхэмжлэгч, хариуцагч болон бусад оролцогчид асуулт тавих, үйлчлүүлэгчийнхээ гаргаж байгаа мэдүүлэг, тодорхойлолтонд тайлбар хийх;
- ◆ Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай баримт бичгийг байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авахаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчид хүсэлт гаргах, баримт сэлтийг бэхжүүлэх зорилгоор дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглах;
- ◆ Давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд өөрийн санаачлагаар буюу шүүгдэгчийн хүсэлтээр оролцож санал, дүгнэлт гаргах;
- ◆ Хууль тогтоомжид заасан бусад эрх эдэлнэ.

## ӨМГӨӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ

Өмгөөлөгч нь хуульд заасан дараах эрх үүрэг хүлээнэ.

- ◆ Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон өмгөөлөгч, хуульчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;
- ◆ Үйлчлүүлж байгаа этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах бүх арга хэрэгслийг ашиглан тууштай хамгаалах;
- ◆ Өмгөөллийн үүрэг гүйцэтгэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүн болон үйлчлүүлэгчийн нууцыг задруулахгүй байх;
- ◆ Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх;
- ◆ Эрүүгийн хэрэгт өмгөөллийн үүрэг гүйцэтгэх явцад үйлчлүүлэгчээс дахин гэмт хэрэг үйлдэх тухай мэдсэн тохиолдолд энэ тухай цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

- ◆ Үйлчлүүлэгчийн гэм буруу нотлогдсон, эсхүл нотлогдохгүй байгаа талаар нийтэд мэдэгдэхгүй байх;
- ◆ Өмгөөлөх байгууллагаас өгсөн томилолтыг биелүүлэх.

## ӨМГӨӨЛӨГЧИЙН ХАРИУЦЛАГА

Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа явуулах үедээ хууль тогтоомж, өмгөөлөгчийн болон хуульчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн бол дараах сахилгын шийтгэл оногдуулна.

- а. Сануулах;
- б. Өмгөөлөл эрхлэх эрхийг хасах тухай урьдчилан сануулах;
- в. Өмгөөлөл эрхлэх эрхийг хасах;

Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг мэргэжлийн болон сахилгын хорооны саналыг үндэслэн Хууль зүй дотоод хэргийн сайд шийдвэрлэнэ.

**Хэрэгт оролцох талаар тохиролцсон буюу томилогдсон үеэс өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээс татгалзах, хууль бусаар нотлох баримт цуглуулах эрхгүй.**

*/ЭБШХ- 41 дүгээр зүйлийн 41.2/*

## 1.2. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ БА ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХ

Монгол Улсын эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, гэм буруутай, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Эрүүгийн гэмт хэрэг гэдэг нь захиргааны зөрчлөөс нийгмийн хор аюулын хэмжээгээр ямагт илүү байдаг. Ийм ч учраас нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан үзсэний үндсэн дээр гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн шинж бүхий үйлдэл нь эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцааны эсрэг чиглэсэн идэвхтэй үйлдэл (дээрэмдэх, танхайрах, хулгайлах, хээл хахууль авах гэх мэт) болон гэм буруутай этгээд үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, үүрэгт ажилдаа хайхрамжгүй хандсан (Хөдөлмөр хамгааллын зааварчлага өгөхгүй байх, эмнэлгийн ажилтан бусдад тусламж үзүүлэхгүй байх, гэмт хэргийг үл мэдээлэх гэх мэт) идэвхгүй буюу эс үйлдэхүй гэсэн байдлаар илэрнэ.

Эдгээр үйлдэл, эс үйлдэхүй дангаараа эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл болохгүй бөгөөд заавал гэм буруутай байхыг шаардана. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн санаа зорилго нь санаатай, болгоомжгүй хэлбэрээр илэрнэ. Гэмт хэргийг санаатай үйлдэх гэдэг нь нэгдүгээрт, гэмт этгээд өөрийн үйлдэл буюу эс үйлдэхүйн нийгмийн хор аюулыг урьдчилан ухамсарласан, хоёрдугаарт, түүнээс болж нийгэмд учирч болох хор уршгийг урьдаас мэдсэн, гуравдугаарт, тэр хор уршгийг буй болгохыг хүссэн байдаг.

Харин гэмт хэргийг болгоомжгүй үйлдэхдээ түүний улмаас учирч болох хор уршгийг ухамсарлаж, урьдаас мэдэж байсан боловч тэр хор уршгийг гаргахгүй байж чадна гэж өөрийн болон бусдын хүчинд итгэж хөнгөмсгөөр найдсан, хайхрамжгүй хандсан байдаг онцлогтой.

Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн, ухаан мэдрэл бүрэн байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Мөн зарим онцгой тохиолдолд 14-16 хүртэлх насны хүүхэд эрүүгийн хариуцлагад татагдаж болно. Үүнд:

- ◆ Хүнийг санаатай алах
- ◆ Бусдын биед хүнд гэмтэл санаатай учруулах

- ◆ Хүчиндэх
- ◆ Бусдын эд хөрөнгийг хулгайлах
- ◆ Бусдын эд хөрөнгийг булаах
- ◆ Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх
- ◆ Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх
- ◆ Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах

Гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэх, завдах, гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах, гэмт хэрэгт хамтран оролцох (захиалагч, зохион байгуулагч, хатгагч, хамжигч, гүйцэтгэгч) хэлбэрүүдийг зөв тайлбарлахад танд өмгөөлөгчийн туслалцаа хэрэгтэй болно.

Дараахь тохиолдолд сэжигтнээр тооцож, тогтоол үйлдэнэ.

- ◆ Гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан
- ◆ Хохирогч буюу харсан хүн шууд заасан
- ◆ Бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр илэрч олдсон
- ◆ Үйлдсэн хэргээ илчлэн ирсэн



*Намайг ямар хэрэгт сэрдэж байгаа юм бэ?*

---

Ийнхүү хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч таныг сэжигтнээр тооцож, тогтоол үйлдсэн үеэс та өөрийгөө өмгөөлөх буюу өмгөөлөгчийн туслалцаа авах эрхтэй болно.



Ихэнх тохиолдолд иргэд өөрт нь ямар нэг асуудал тулгарсны дараа өмгөөлөгч болон хууль зүйн туслалцаа үзүүлэх хүнийг хайж эхэлдэг. Зүй нь та эхлээд хууль зүйн туслалцаа шаардлагатай ямар нэг асуудал тулгарвал хэнд хандах вэ гэдгээ өмнө нь шийдвэрлэсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл асуудал тулгарсан үед биш түүнээс өмнө та эрх ашгаа хамгаалах хамгаалалтыг өмгөөлөгчийн тусламжтайгаар бий болгох боломжтой юм. Хууль зүйн зөвлөгөө авах урьдчилсан мэдээлэл нь хуульчдын үзүүлдэг хамгийн чухал үйлчилгээ буюу “урьдчилан сэргийлэх тарилга” юм.

Иргэд өмгөөлөгчийг зөвхөн шүүхэд шилжсэн үед авах хэрэгтэй гэсэн ташаа ойлголттой байдаг нь судалгааны дараах дүнгээр харагдаж байна. “Та хэдийд өмгөөлөгч авах эрхтэй вэ?” гэсэн асуултанд иргэдийн хариулсан байдал:

- ◆ Эрүүгийн хэрэг үүсгэсэн үеэс -16%
- ◆ Албадлагын арга хэмжээ авсан үеэс-33%
- ◆ Хэрэг шүүхэд шилжих үеэс-39%
- ◆ Сэжигтэнээр тооцогдсон үеэс-12%

Ямар нэг эрүүгийн гэмт хэрэгт холбогдон сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол дараахь мэдээллийг шаардан авах эрхтэй бөгөөд энэ нь өөрийгөө өмгөөлж байгаа хэлбэр юм. Үүнд:

*Эрцүгийн хэрэгт  
сэрдэгдсэн боловч би эдгээр  
эрхийг эдлэнэ.*



- ◆ Ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа асуух
- ◆ Ямар хэрэгт яллагдаж буйгаа асуух
- ◆ Өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолыг шаардан авч уншиж танилцах
- ◆ Шинжээч томилсон тогтоолтой танилцаж, шинжээчид нэмэлт асуулт тавих
- ◆ Шинжээчийн дүгнэлттэй танилцах
- ◆ Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт дууссаныг мэдэгдсэний дараа хэргийн бүх материалтай танилцах
- ◆ Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоолтой танилцах

Мөн гомдол, хүсэлт тайлбар гаргах замаар сэжигтэн, яллагдагч нар эрхээ хамгаалах боломжтой болохыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тодорхой заасан байдаг. Үүнд:

- ◆ Нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах
- ◆ Сонсгосон зүйл ангийн талаар бичгээр болон амаар тайлбар гаргах
- ◆ Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах
- ◆ Учирсан хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах
- ◆ Хавтаст хэргийн материалтай танилцах үедээ бичгээр хүсэлт гаргасан бол хэрэгт хавсаргана
- ◆ Хэргийг хэрэгсэхгүй болгосон өдрөөс хойш 7 хоногийн дотор прокурорт гомдол гаргаж болно
- ◆ Анхан шатны шүүхийн тогтоолыг гардан авсан буюу танилцуулсанаас хойш 10 хоногийн дотор давж заалдах
- ◆ Гомдол гаргах эрхтэй

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд биечлэн оролцох хэлбэрээр өөрийгөө өмгөөлөх боломжууд:

- ◆ Байцаалтанд оролцож, мэдүүлгээ тодруулсан зураглал, хүснэгт зураг зурж байцаалтын тэмдэглэлд хавсаргах
- ◆ Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчаас зөвшөөрөл авч нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг байцаан шийтгэх ажиллагаанд оролцох
- ◆ Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зөшөөрөлтэйгээр шинжилээ хийхэд оролцох
- ◆ Шаардлагатай хэмээн үзвэл туршилт хийх үед сэжигтэн, яллагдагчийг оролцуулах
- ◆ Шүүх хуралдаанд оролцож эцсийн үг хэлэх.



Ийнхүү иргэн та Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар байцаалтад оролцох, нэмэлт нотлох баримт гаргаж өгөх зэргээр өөрийн эрх, ашиг сонирхолоо хамгаалах өргөн боломжтой юм.

## ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮЕД ТА ЯМАР ЭРХТЭЙ ВЭ?

Эрүүгийн хэргийн шалгах явцад хэрэгт ач холбогдол бүхий баримтыг тодруулах, шинжлэх ухааны тусгай мэдлэг шаардлагатай үед шинжилгээний байгууллагад хандаж шинжээчийн дүгнэлт гаргуулахыг хуулиар зөвшөөрсөн байдаг. Практикт хамгийн түгээмэл хийгддэг шинжилгээний нэг нь шүүх эмнэлгийн шинжилгээ бөгөөд гэмтлийн зэрэг тогтоох, үхлийн шалтгааныг тодорхойлох, цусны бүлэг тогтоох гэх мэт.

Шинжилгээ хийх үед өмгөөлөгч нь тогтоолтой танилцах, шинжээчид асуулт тавих, шинжээчийг байцаахад байлцах, шинжээчийн дүгнэлттэй танилцсаны дараа нэмэлт ба дахин шинжилгээ хийх хүсэлт гаргах зэргээр үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалж бодит үнэнийг тогтооход тусладаг.

Эрүүгийн хэргийг шалгах явцад заавал шинжилгээ хийх тохиолдлууд:

- ◆ Гадны нөлөөлөл буюу сэжигтэй байдлаар нас барсан
- ◆ Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэг хариуцах чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл сэтгэцийн байдлыг тодорхойлох
- ◆ Гэрч, хохирогчийн сэтгэцийн байдалд эргэлзээ төрөх Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн насыг тогтоох
- ◆ Онц хүнд гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох

Зарим үед хими, биологи, техникийн, галт зэвсгийн, ня-бо бүртгэлийн, урлаг, гар урлалын зэрэг нарийн мэргэжлийн шинжилгээ хийх шаардлагатай байдаг.

**Шинжилгээ хийлгэх үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч дор дурдсан эрх эдлэнэ.**

- ◆ **Шинжээчийг татгалзан гаргах хүсэлт гаргах**
- ◆ **Шинжээчид нэмэлт асуулт тавих**
- ◆ **Шинжээчийг нэмэлт баримт бичиг өгөх, тэр талаар тайлбар гаргах**
- ◆ **Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрөлтэйгээр шинжилгээ хийхэд байлцах**
- ◆ **Шинжээчийн дүгнэлттэй танилцах**

/ ЭБШХуулийн 157 дугаар зүйлийн 157.1/

## ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНД ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХИЙГ ХЭН ХАНГАХ ВЭ?

Таны өмгөөлүүлэх эрхийг хангах албан тушаалтан:

- ◆ Хэрэг бүртгэгч
- ◆ Мөрдөн байцаагч
- ◆ Прокурор
- ◆ Шүүгч

Монгол Улсын шинэ ЭБШХ-ийн 18-р зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх нь өмгөөлүүлэх эрхийг хангах, энэ эрхээ эдлэх нөхцөл бололцоог иргэн хүнд бүрдүүлж өгөх үүрэгтэй болохыг хуульчлан заажээ.

**Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогч бусад этгээдэд тэдгээрийн эрх, үүрэг болон үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг тайлбарлан өгч, байцаан шийтгэх ажиллагааны явцад эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.**

(ЭБШХ-ий 187 дугаар зүйлийн 187.1)

Эрүүгийн хэргийг шалгаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж болохгүй бөгөөд харин тухайн этгээд өмгөөлөгч аваагүй бол түүний хүсэлтээр өмгөөлөгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох боломжийг хангаж өгөх ёстой.

Гэмт хэрэгт сэжиглэн баривчлах арга хэмжээ авах нь хууль зүйн үндэслэлтэй боловч мөрдөн байцаагч сэжигтний эрхийг хамгаалсан заалтыг ноцтой зөрчсөн эсэхэд прокурор хяналт тавина.

**Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгааг нь 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчилагдсан этгээдэд олгоно.**

(ЭБШХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.1)

Баривчлах болон цагдан хорих арга хэмжээ авсан хэн боловч өөрөө болон өмгөөлөгчөөрөө дамжуулан эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

Баривчлагдсан, цагдан хоригдсон хүнийг түр хугацаагаар нийгмээс тусгаарлаж, эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа тул түүний асрах хүнгүй үлдсэн бага насны хүүхэд, өндөр настай эцэг эх болон бусад асруулагчийг харгалзан дэмжих байгууллага хувь хүмүүст шилжүүлэн өгөх үүргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүлээнэ. Түүнчлэн эзэнгүй үлдсэн эд хөрөнгө, орон сууцыг хамгаалах арга хэмжээ авах ёстой.



### 1.3 ИРГЭНИЙ МАРГААН БА ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХ

Хүний эрхийг хамгаалах зөрчигдсөн эрхийг нь сэргээх гол механизм бол шүүх, түүний бие даасан болон шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх, улмаар бүх төрлийн шүүхийн хяналтыг хүчтэй болгох явдал байдаг юм.

Иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх явцад хүний эрх зайлшгүй хөндөгдөнө. Иймд

Хүний эрх, эрх чөлөөний баталгаа нь:

- ◆ Хууль, шүүхийн өмнө хүн бүр үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол түүнчлэн аж ахуйн нэгж, өмчийн байдал, эрх хэмжээний ялгаваргүйгээр эрх тэгш оролцож байгаа явдал,
- ◆ Шүүх хуралд иргэдийн төлөөлөгч оролцож байгаа байдлаар,
- ◆ Эрх нь зөрчигдсэн этгээдийн эрх ашиг сонирхлыг шүүхээр хамгаалах явдал юм.

Шүүх нь Монгол улсын хууль, олон улсын нэгдэн орсон олон талт гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар хуульд заасны дагуу нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргасныг шийдвэрлэх, шийдвэр нь заавал дагаж мөрдөх хуулийн адил хүчинтэй байна.



Шүүхээр шийдвэрлэх иргэний хэрэг нь эрх ашиг, сонирхол хөндөгдсөн талуудын хоорондох үүсч байгаа маргааныг шийдвэрлэх явцад үүсдэг.

Тэгвэл иргэний маргаан гэдэг нь эдийн засгийн суурь харилцаанд тулгуурласан иргэд, хуулийн этгээдийн эрхтэй ба эрхгүй байгууллагын өмчлөх эрх, эзэмшил, өв залгамжлал болон гэрээний үүрэг ба гэрээний бус үүрэг (эрх) зөрчигдөх тохиолдолд бий болно.

Иргэний хэрэг маргаанд оролцож байгаа талууд өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Энэ боломж нь хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх, үүргээр тодорхойлно. Ингэхдээ ямар эрх эдлэх вэ гэдгээ мэдэж байвал эрхээ хамгаалахад илүү дөхөмтэй байна. Тухайлбал,

- ◆ Нэхэмжлэгчийн шаардлага, түүнд өгсөн татгалзал, түүнийг нотлож байгаа баримттай танилцах, тайлбар өгөх
- ◆ Хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох
- ◆ Шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах
- ◆ Гэрчээс мэдүүлэг авахуулах
- ◆ Шинжээч томилуулах
- ◆ Хуурамч нотлох баримт бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах



- ◆ Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах
- ◆ Шүүх хурлын явцад оролцогчдод асуулт тавих
- ◆ Шүүхийн шийдвэрт давах, хяналтын журмаар гомдол гаргах
- ◆ Шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар өгөх
- ◆ Нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг гаргаж өгөх
- ◆ Шүүхэд дуудсанаар ирэх
- ◆ Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Эрх нь зөрчигдсөн тал буюу нэхэмжлэгч, эрх ашгийг зөрчсөн гэж үзэж байгаа тал буюу хариуцагч аль аль нь дээрх эрхийг хэрэгжүүлэх бүрэн боломж хангагдсан байдаг. Эдгээр эрх (үүргийг)-ийг хэрэгжүүлснээр иргэний хэрэг маргаанд мэтгэлзэх зарчмыг хэрэгжүүлэх, нөгөө талаар өөрөө өөрийгөө өмгөөлөх нөхцлийг хуулиар бүрдүүлжээ.

Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлийн хэмжээг ихэсгэх, багасгах, түүнчлэн шүүхийн ажиллагааны аль ч шатанд нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй. Мөн нэхэмжлэгч, хариуцагч талууд нэхэмжлэлээс татгалзах эсвэл нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх байдлаар эвлэрэх эрхтэй. Энэ нь шүүхийн ажиллагааг хөнгөвчлөх, зардал буюу улсын тэмдэгтийн хураамж гаргахгүйгээр маргаан шийдэгдэх зэрэг давуу талтай байна. Бусад улс оронд ч шүүхээр шийдвэрлүүлэхээс өмгөөлөгч илүү эвлэрүүлэх ба зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг товчоо ажилладаг байна.

Хариуцагчийн өөрийгөө хамгаалах нэг боломж нь сөрөг нэхэмжлэл байдаг юм. Нэхэмжлэгчээс шаардах шаардлагаа харилцагч нь сөрөг нэхэмжлэлээр шийдвэрлүүлж болно. Гэхдээ сөрөг нэхэмжлэл нь нэхэмжлэгчийн шаардлагын эсрэг буюу түүний хүрээнд хамааралтай байх шаардлагатай. Гэхдээ үүссэн иргэний хэрэг маргаан нарийн төвөгтэй, эрх зүйн мэргэжлийн мэдлэг шаардлагатай гэж үзвэл өмгөөлөгчийн туслалцааг авч болно.

Шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа иргэн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө сонгон авах, эрхтэй

ба шүүх энэ эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүргийг хүлээдэг.

**Иргэний маргаанд өмгөөлөгч нь ямар үүрэг, эрх эдлэн оролцох вэ?**

1. Шаардлагатай нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх, ач холбогдол бүхий баримт бичгийг байгууллага, аж ахуй нэгжээс гаргуулах, хувилж хуулбарлан авах, тэмдэглэл хийх.

2. Эсрэг талын болон бусад оролцогчдын гаргасан нотлох баримт, шаардлага, татгалзал, тайлбартай танилцах, тайлбар өгөх.

3. Шүүхэд (гэрч оролцуулах, шинжээч томилуулах, шүүх хуралдааныг хойшлуулах гэх мэтээр) хүсэлт гаргах

4. Шүүх бүрэлдэхүүн оролцогчдыг татгалзан гаргах

5. Шүүхийн шийдвэрийг давж заалдах


6. Хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хэрэгжүүлнэ.

Иргэний хэргийг шийдвэрлүүлэхээр шүүхэд хандахад тэргүүн ээлжинд аль шүүхэд өргөдөл, нэхэмжлэлээ гаргаж өгөх вэ гэдэг асуудал тулгарна. Үүнийг шүүхийн харъяалал гэх бөгөөд энэ тохиолдолд эрхийг нь хэн зөрчсөн болох (иргэн үү, байгууллага уу), хаана оршин суух зэргээр харъяаллыг тогтооно.



Хариуцагч нь иргэн бол нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд, харин хуулийн этгээд бол ажил хэргээ байнга явуулдаг, удирдах байгууллага нь байгаа газрын шүүхэд гаргана.





Шүүхэд нэхэмжлэл гаргахад эрх зөрчигдсөн болохыг тодорхойлохоос гадна түүнийг нотлох шаардлагатай баримт бичгийг хавсаргах нь хэргийг бодитой, түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. Иргэдийн хооронд эд зүйлс худалдах гэрээ байгуулсан тохиолдолд эд зүйлийн үнэ өртөгийг харилцан тохирсон болохыг тодорхойлсон баримт, гэрээ, гэрч байх, мөн хүүхдийн эцэг тогтоолгох хүсэлтийг гаргасан бол хүүхдийн эцэг болох иргэнтэй хамтран амьдарч байсныг нотолсон байх шаардлагатай.

Энэ нь нэг талаар нэхэмжлэгч, хариуцагчийн хувьд үүрэг болно. Өөрийн шаардлагыг болон татгалзалыг нотлох баримтаар нотлох, түүнийг бүрдүүлэх нь талуудын гүйцэтгэх ажиллагаа байдаг. Хэрэв талууд өмгөөлөгчөөр үйлчлүүлэхээр тохирсон бол нотлох баримт бүрдүүлэх, тайлбар өгөх үүргийг өмгөөлөгч түүний өмнөөс гүйцэтгэж болно.

*За ингээд өгсөн  
авсандаа өлзийтэй.  
Энэ чинь худалдах,  
худалдан авах гэрээ  
хийсэн гэсэн үг шүү  
дээ*



Иргэний маргааныг шүүхэд үүсгэх үндэслэл нь нэхэмжлэл байдаг.

Нэхэмжлэл гэдэг нь маргаж байгаа болон зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахын тулд хуулиар тогтоосон журмын дагуу шүүхэд хандаж нэхэмжлэгчээс хариуцагчид тавьсан шаардлага мөн.

*Нэхэмжлэгч  
гэж хэнийг  
хэлэх вэ?*

Нэхэмжлэгч гэдэг нь эрхээ зөрчигдсөн гэж үзэж шүүхэд нэхэмжлэл, өргөдөл гаргаж буй иргэн, хуулийн этгээд юм.

*Хариуцагч  
гэж хэнийг  
хэлэх вэ?*

Хариуцагч гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж нэхэмжлэл, өргөдөлд дурдагдсан иргэн, хуулийн этгээд юм.

Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд, түүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нэхэмжлэгч болон төлөөлж буй этгээд гарын үсгээ зурсан байна.

Нэхэмжлэлд дараахь зүйлийг тусгасан байна.

- ◆ Нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа,
- ◆ Нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар,
- ◆ Хариуцагчийн овог, эцгийн нэр хаяг, оршин байгаа газар,
- ◆ Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт,
- ◆ Нэхэмжлэлийн үнэ,
- ◆ Хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

**Сүхбаатар дүүргийн шүүхэд нэхэмжлэл  
гаргах нь:**

2005.1.10

Ажлаас үндэслэлгүй  
халсан тухай

*Нэхэмжлэгч: Аюур овогтой Баяр Улаанбаатар хотын ...дугаар цэцэрлэгт багш ажилтай байсан . СБД-н 1-р хороо 13-24 тоот утас .....*

*Хариуцагч: Улаанбаатар хотын СБД –ийн ...дугаар цэцэрлэгийн дарга Төмөрчөдөр овогтой Сэргэлэн ЧД-ийн 8-р хороо 24-3 тоот утас .....*

*Нэхэмжлэлийн утга: Аюур овогтой Баяр би 1984 оноос цэцэрлэг яслийн системд 21 жил ажиллаж ирсэн бөгөөд энэ хугацаанд байгууллага системийн тэргүүний ажилтан, оны аварга багш зэрэг цол, шагнал удаа дараа авч байсан. СБД-ийн ...дугаар цэцэрлэгт 1998 оноос хойш ажиллаж байгаа. Манай цэцэрлэгийн удирдлага 2003 онд өөрчлөгдсөн. Шинээр ирсэн дарга Сэргэлэн нь 2003 оны хоёрдугаар сард ажлаа авснаас хойш цэцэрлэгийн зургаан багшийг халаад байна. Сэтгэлд нь нийцэхгүй, санаанд нь таалагдаагүй багш, ажилтныг халах, ингэснээр тэр хүний амьдралаар тоглож байна. Намайг сургалтын шинэ арга ангидаа нэвтрүүлж нээлттэй хичээл явуулахад энэ хичээлийн жилийн төлөвлөгөөнд ороогүй хичээл явууллаа гэж дургүйцсэн. Үүнээс цүдэн манай ангийг өөр ангид шилжүүлэхэд дутсан зарим зүйлсийг надаас нэхэмжилж үнийг гурав нугалж төлүүлэхээр (нийт 120000₮) шийдэн, хэрэв төлөхгүй бол ажлаас хална гэж байгаад 2004 оны нэгдүгээр сарын 2-нд тасалбар болгон ажлаас халлаа. Энэ шаардаж байгаа мөнгө нь өмнөх ангийн багшид төлбөр болж тогтоогдохоор тэр нь өөрийн хүсэлтээр ажлаас гарч, дараа нь одоо надаар төлүүлэх гэж шаардаж байгаа болно. Иймээс 2005-01-02-ны өдрийн ажлаас халсан тушаалыг үндэслэлгүй гэж үзэж байна. Энэ маргааныг хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү.*

*Нэхэмжлэлд:*

1. Ажлаас халсан тушаал
2. Эд хөрөнгийн жагсаалт
3. Төлбөрийн акт (2005 он)
4. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хавсаргав.

Өргөдөл гаргасан : А.Баяр

гарын цсэг.....

Хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг мөн хавсаргана. Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.



“Чи хугацаандаа зээлээ төлөөгүй хүүцээ ч өгсөнгүй”. Ингэхээр шүүцхэд л хандахаас...

Нэхэмжлэлийг шүүхэд гаргаснаар хугацаа тоологдоно. Нэхэмжлэлийг хэрэг үүсгэсэн өдрөөс хойш нийслэлд 7 хоног, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор хариуцагчид гардуулсан байна. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор:

- ◆ Нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх болон татгалзах
- ◆ Нэхэмжлэлийн аль нэг хэсгийг зөвшөөрөхгүй байгаа
- ◆ Сөрөг нэхэмжлэл гаргах зэрэг үйл ажиллагаа явуулна.

Дээрхи (14 хоног) хугацааг хожимдуулсан нь хариуцагчид сөрөг нөлөөтэй. Хуульд заасан хугацаанд хариу тайлбараа өгөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөнд тооцож, түүний байхгүйд хэргийг шийдвэрлэж болно.

Шүүх өргөдлийг хүлээн авч хянаад, нэгд: нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлтгэх, хоёрт: нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, гуравт: нэхэмжлэлийг арбитрт шилжүүлэх гэсэн гурван шийдвэрийн аль нэгийг гаргана.

Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт байна.

Иргэдийн нэхэмжлэл гаргахдаа ямар маргаан вэ гэдгээс шалтгаалж улсын тэмдэгтийн хураамж төлнө.



Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдон үйлчилгээ үзүүлсний төлөө маргаанд оролцогч талуудаас төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ. Улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан нэхэмжлэгчээр төлүүлэн нэхэмжлэлд тавьсан шаардлагыг шүүх бүрэн хангасан бол хариуцагчаар төлүүлэн, нэхэмжлэгчид буцаан олгоно.

*Нэхэмжлэлээ ч биччихлээ,  
харин УТХ-ийг яаж төлөх вэ?*




Нэхэмжлэл гаргах үед түүний үнийг шууд тогтооход бэрхшээлтэй байвал шүүгч улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг урьдчилан тогтоож, тухайн хэрэг хянан шийдвэрлэсний дараа шүүхээс тогтоосон нэхэмжлэлийн үнэд тохируулан нөхөн төлүүлэх буюу урьд илүү төлөгдсөн бол зөрүүг буцааж олгоно.

Маргаж буй талуудын эд хөрөнгө болон бусад байдлыг харгалзан шүүхээс улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол улсын тэмдэгтийн хураамжийг хураасан хэмжээгээр нэхэмжлэгчид шүүгчийн захирамжаар буцаан олгоно. Давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө түүнээсээ татгалзвал тухайн шатны шүүгч гомдлыг гаргаагүйд тооцох, тухайн шатны шүүхэд гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох захирамж гаргана. Хяналтын шатны шүүх талууд, гуравдагч этгээдийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэж шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон буюу өөрчилсөн тохиолдолд гомдол гаргагчаас тухайн шатны шүүхэд гомдол гаргахдаа төлсөн Улсын тэмдэгтийн хураамжийг тухайн шатны шүүгчийн захирамжаар буцаан олгоно.

Нэхэмжлэгч шаардлагаа багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, талууд эвлэрэх замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол Улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.



Шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргахад дор дурьдсан хэмжээгээр хураамж хураана.

1. Эд хөрөнгийн чанартай бөгөөд үнэлж болох нэхэмжлэлд доорх хүснэгтэд зааснаар:

Нэхэмжлэлийн үнэ/төгрөгөөр/	Хураамжийн хувь хэмжээ
0-3000	50 төгрөг
3001-10000	Нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2%
10001-50000	200 төгрөг дээр 10000 аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 3.5%
50001-500000	1500 дээр 50000 аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 4%
500001-1000000	19500 дээр 500000 аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2.1%
1000001-10000000	30000 дээр 1000000 аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 1.4%
10000001-аас дээш	156000 дээр 10000000 аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0.5%

2. Эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд 250 төгрөг
3. Хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутмаас 25 төгрөг.

### **НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСНААР ШҮҮХ ЯМАР АЖИЛЛАГАА ХИЙХ ВЭ?**

Нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шүүгчийн ажиллагаа зөвхөн хуульд заасан зарчим, эрэмбэ дарааллын дагуу хийгдэх ёстой. Хуулиас гадуур хэргийн талуудын эрх ашгийг хохирооход чиглэсэн аливаа үйл ажиллагаа хийхийг хориглоно.

Нэхэмжлэгч, өмгөөлөгч, төлөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол нэхэмжлэлийг буцаах, эсхүл хариуцагчийн хүсэлтээр тэдгээрийг оролцуулахгүйгээр хурлыг хийж болно.

Хэрэв нэхэмжлэгч өөрийн эзгүйд хүндэтгэн үзэх шалтгаанаар өмгөөлөгчийг оролцуулан шүүх хуралдааныг явуулж болно гэсэн бичгээр хүсэлт гаргасан бол шүүх хуралдааныг явуулна.

Харин гэрлэлт цуцлахтай холбоотой хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч өөрсдөө ирэх үүрэгтэй. Хэн нэг нь ирээгүй бол хуралдааныг хойшлуулна. Мөн хоёр дахь удаагаа хариуцагч ирээгүй бол хэргийг хянан шийдвэрлэх, нэхэмжлэгч ирээгүй бол нэхэмжлэлийг буцаана.

Хариуцагч, түүний өмгөөлөгч, төлөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралд ирээгүй бол нэхэмжлэгч нь түүний эзгүйд хурал хийх тухай хүсэлт гаргасан тохиолдолд шүүх уг хүсэлт, хэрэгт байгаа баримт нотолгоог үндэслэн хэргийг шийдвэрлэнэ. Энэ хүсэлтийг нэхэмжлэгч гаргаагүй ч шүүх нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэж болно. Энэ шийдвэр нь ердийн шийдвэрийн адил хүчинтэй байна.



Шүүх хурлын бэлтгэл үе шатанд шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг төрөл садан, хэргийн оролцогчидтой хувийн харьцаатай, мөн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал өөрсдөө болон шүүх хуралд

нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд хүсэлт гаргаж татгалзаж болно.

Нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа эсэх, хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг тодруулан, талуудын тайлбарыг нотлох баримтын үндсэн дээр хэргийг авч хэлэлцэнэ. Өмгөөлөгч өөрийн үйлчлүүлэгчийн эрх ашгийг хууль, эрх зүйн үүднээс дүгнэж тайлбар хийх, талуудаас асуух, нотлох баримтад тулгуурлан санал, дүгнэлт гаргана.

**Төр, байгууллага, хувь хүний нууцтай холбогдсон баримтыг шүүх хуралд танилцуулахгүй.**

*/ИХШХШТ Хуулийн 110 дугаар зүйлийн 110.2 дахь хэсэгт/*

*Би өмгөөлөгчгүй шүүх хуралд оролцож,  
өөрөө өөрийнхөө эрхийг хамгаална.*



Анхан шатны шүүхээс хэргийн талаар дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1. Нэхэмжлэлийн шаардлагыг хангах;
2. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох;
3. Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

**Шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болох уу?**

Анхан шатны шүүх шийдвэрийг уншиж сонгосноор хойш 7 хоногийн дотор бичгээр нэхэмжлэгч, хариуцагчид гардуулна.


Хяналтын журмаар хэрэг хянуулахаар бол 30 хоногийн дотор гомдол гаргана.

Давж заалдах гомдлыг шийдвэр авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор гаргана.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг зөвшөөрөхгүй бол гомдол гаргахдаа давж заалдах, эсхүл хяналтын журмаар гаргах эсэхээ сонгон гомдлыг хэрэг хянан шийдвэрлэсэн тухайн шүүхэд ирүүлнэ.

Анхан шатны журмаар хэргийг шийдвэрлээд гаргасан шийдвэрт, нэхэмжлэгч, хариуцагч (зохигч этгээд), тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч давж заалдах гомдол болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.





**Зохиогч талын нэг нь давж заалдах, эсрэг тал нь хяналтын журмаар гомдол гаргасан бол давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хэргийг бүхэлд нь хянана.**

/ ИХШХШ тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.3 /

Давж заалдах гомдолд аль шүүхийн ямар шийдвэрийн ямар заалтыг, ямар үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байгаа, шүүх хуулийг буруу хэрэглэсэн гэж яагаад үзэж байгаа үндэслэлээ өмгөөлөгч ба маргаж байгаа талууд тодорхой тусгах шаардлагатай.

*Таны гомдлыг шүүх хүлээн авснаас хойш 30 хоногт давж заалдах болон хяналтын журмаар шийдвэрлэнэ.*



Давж заалдах шатнаас анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлүүд:

- ◆ Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, шийдвэрийг өөрчлөх боломжгүй
- ◆ Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн
- ◆ Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн
- ◆ Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн, шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүн ороогүй байхад шүүгч гарын үсэг зурсан
- ◆ Хуурамч нотлох баримтыг үндэслэн хэргийг хянан шийдвэрлэсэн нь давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд илэрсэн.

Хяналтын шатны шүүхэд

- ◆ Шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн
- ◆ Хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн (нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг биечлэн оролцох хэрэгт оролцуулаагүй, хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг шийдвэрлэсэн, хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн) гэсэн үндэслэлээр гомдол гаргана.





Талууд ба хэргийн бусад оролцогч, түүнчлэн тэдгээрийн эрх залгамжлагч шүүхээр нэгэнт хянан шийдвэрлэсэн маргааны талаар дахин шүүхэд нэхэмжлэл гаргах буюу шүүхээс нэгэнт тогтоосон үйл баримт, эрх зүйн харилцаа, иргэний хэрэг хянан шийдвэрлэх өөр ажиллагааны талаар маргах эрхгүй.


Шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэргийн оролцогчийн хүсэлтээр гагцхүү уг шийдвэрийг биелүүлж эхлэхээс өмнө түүний хууль зүйн үндэслэлийг аман эсхүл бичгийн хэлбэрээр тайлбарлаж болно.

#### 1.4. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ БА ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХ

Хүмүүс хүний эрх, хууль, зөрчил, гэмт хэрэг гэсэн ойлголтуудыг ихэвчлэн шүүх, цагдаа гэх мэт байгууллагуудтай холбон ойлгож өдөр тутам харилцаанд нь ордог, үйлчилгээг нь хүртдэг, эрхээ эдэлдэг харилцааг тэр бүр анзаардаггүй. Энэ харилцаа бол нэг талаас захиргаа (жишээлбэл Засаг дарга, эрчим хүчний захиргаа гэх мэт) нөгөө талаас иргэн Та оролцдог харилцаа юм.




Иргэд Үндсэн хуульд заасан олон төрлийн эрхээ эдлэх, үүргээ биелүүлэхдээ захиргааны байгууллагатай өдөр тутам харилцдаг. Энэхүү харилцаа хамгийн энгийн зүйлээс эхэлнэ. Янз бүрийн тодорхойлолт гаргуулах (өрхийн, амьдран суудаг гэх мэт)-аас эхлээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөл авах зэрэг олон төрлийн харилцаа үүсдэг.



Эдгээр харилцааг дотор нь хоёр хувааж болно.

1. Иргэн Үндсэн хуульд заасан эрхээ эдлэхтэй холбоотой үүсэх харилцаа
2. Иргэн үүргээ биелүүлэх, эсэхээс үүссэн зөрчилтэй холбоотой харилцаа



## НЭГ. ИРГЭН ЭРХЭЭ ЭДЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААНД ӨМГӨӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ

Иргэд Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шүүх, цагдаагийн байгууллагаас гадна захиргааны байгууллагуудтай харилцах шаардлага байнга гардаг тухай дээр дурьдсан билээ. Энэхүү харилцааны гол онцлог бол иргэн өөрөө эрх зүйн зөрчил гаргаагүй байсан тохиолдолд ч өмгөөлөгчийн туслалцаа авч болдогт оршино.

*Цайны газар нээхэд ямар зөвшөөрөл хэрэгтэй вэ?*



Дээрх жишээнээс хэд хэдэн дүгнэлт хийж болно. Үүнд:

1. Иргэн, захиргаа хоёрын хооронд үүсэх харилцаа харьцангуй өргөн бөгөөд янз бүрийн асуудлаар захиргааны байгууллагатай харилцах шаардлага байнга гардаг.

2. Төрийн байгууллагатай харилцахад иргэд өөрсдөө хууль дүрмээ сайтар мэддэг байх ёстой. Гэхдээ энэ бол тэр бүр боломжтой зүйл биш. Тиймээс хууль зүйн мэргэшсэн туслалцаа зайлшгүй шаардлагатай болдог.
3. Өмгөөлөгч зөвхөн ямар нэг хэрэг зөрчил, маргаантай асуудалд хэрэг болдог гэдэг нь өрөөсгөл ойлголт. Дээрх тохиолдолд цайны газар ажиллуулах зорилготой Цэрэн өөрөө ямар нэг зөрчил гаргаагүй, гэхдээ түүнд хууль зүйн туслалцаа шаардлагатай болсон.

Өмгөөлөгч-хуульч нь иргэнийг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад бүхий л талаар тусалдаг.

Үндсэн хуульд заасан нэг чухал эрх бол “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрх” байдаг. Иргэд аливаа байгууллагад хандахдаа тухайн байгууллагын эрх хэмжээ (бүрэн эрх), өргөдөл, гомдолд тавигдах шаардлага, тэдгээрийг шийдвэрлэх хугацаа зэргийг тэр бүр нарийн мэддэггүйгээс асуудлыг шийдвэрлэх ёсгүй байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл гаргах, тэднээсээ хариу шаардах, хугацаа алдах, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн байхад “хүлцэнгүй”-гээр хүлээх зэргээр энэхүү эрхээ эдэлж чадахгүй байх тохиолдол элбэг байдаг.

Та өргөдлөө гаргах ёсгүй албан тушаалтанд гаргавал цаг хугацаа алдана. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн бүх зүйлийг шийдэх эрх мэдэлгүй. Энэ тохиолдолд хуульч-

өмгөөлөгчийн туслалцааг хэрхэн авч болох бэ? Та захиргааны байгууллага, албан тушаалтанд өргөдөл эсхүл гомдол гаргана.

Иргэд өргөдөл гаргаж төрийн байгууллага, албан тушаалтанд хандахдаа тухайн этгээдийн бүрэн эрх, эрх хэмжээг тэр бүр мэддэггүйгээс асуудлаа шийдүүлж чадахгүй байдалд хүрдэг. Түүнээс гадна өргөдөлд тавигдах наад захын шаардлагыг (буцах хаяг бичих гэх мэт) хангахгүй тохиолдол гардаг. Энэ бүхэн нь тухайн хүний шууд буруу биш бөгөөд чухам ийм л үед хуульч-өмгөөлөгч хэрэгтэй болдог байна. Хэрэв та өөрөө бичих бололцоогүй байвал өмгөөлөгчөөр (итгэмжлэгдсэн төлөөлөгч) бичүүлж болно. Таны өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага хойш тавих эрхгүй.

Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж өргөдөл хүсэлт гаргасан бол түүнийг шийдвэрлэх цаг хугацаа нэн чухал. Хуульд зааснаар аль ч байгууллага, албан тушаалтан 30 хоногийн дотор, хэрэв энэ хугацаанд амжихгүй бол дахин 30 хоног сунгаснаар нийт 60 хоногийн дотор шийдэх ёстой.



Иргэд ийм төрлийн харилцаанд оролцох явцад захиргааны байгууллагын зүгээс Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг хязгаарлах, боогдуулах, хуульд заасан үүргээ биелүүлэхгүй байх зэргээр хууль зөрчих явдал нилээд түгээмэл байдаг. Бидний хувьд олон жилийн турш хууль, дүрмийг зөвхөн иргэд л зөрчдөг гэсэн сэтгэхүйд автаж захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагаа, түүнээс учирсан хохирлыг төлүүлэх талаар огт хөндөөгүй байсан нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх явдлыг улам бүр газар авахуулахад хүргэхэд тус дөхөм болжээ.

Төр, түүний байгууллага, албан тушаалтан мөн хуулиа биелүүлэхгүй байх явдал бий. Үүнээс болж иргэд хохирдог.

Амьдралд нилээд элбэг тохиолддог захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны жишээг дурьдвал.




1. Эдгээр харилцаанд оролцсон иргэд ямар нэг байдлаар хууль зөрчөөгүй.
2. Захиргааны байгууллагын (Засаг дарга) захирамжилсан шийдвэр гарсан.
3. Захиргааны байгууллагаас гарсан шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол ямар нэг хэмжээгээр хөндөгдсөн эсхүл зөрчигдсөн. Тухайлбал, Цэндийн хувьд “үзэл бодлоо илэрхийлэх”, Долгор “Үл хөдлөх хөрөнгө эзэмших”, Жаргалантын иргэдийн хувьд “эрүүл ахуйн орчинд амьдрах” эрхийн асуудал яригдана.
4. Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд “хууль бус” байдал тодорхой хэмжээгээр ажиглагдаж байна.

Эндээс “захиргааны хэрэг” хэмээх ойлголт үүснэ. Захиргааны хэрэг нь захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаанаас үүдэн гарсан хэрэг, маргаан юм. Энэ хэргийг шийдүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо төлүүлэх үүднээс өмгөөлөгчөөс хууль зүйн мэргэжлийн нарийн зөвлөгөө авах хэрэгтэй болно.

Өмгөөлөгч түүнд хандсан иргэнээс захиргааны актын талаар юуны өмнө тодруулна.

Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа нь бүхэлдээ “акт”<sup>1</sup> хэмээх ойлголтоор илэрхийлэгдэнэ.



Дээр дурдсан жишээ нь дурдагдсан захиргааны байгууллагын хувьд аман шийдвэр, бичмэл шийдвэр-захирамж, үүргээ биелүүлээгүй байдал, захиргааны байгууллагын үйл ажиллагаагаар илэрч байна.

Нэгэнт захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны улмаас иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тул тэд эрхээ сэргээлгэх учиртай.

<sup>1</sup> Акт – латин гаралтай үг бөгөөд үйлдэл, баримт бичиг гэсэн утгуудыг илэрхийлнэ.



## ЗАХИРГААНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ ВЭ?

### Захиргааны хууль бус үйл ажиллагаа

#### Илт хууль бус акт

Захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй зэрэг тохиолдол байвал илт хууль бус акт гэж үзнэ.

#### Маргаан бүхий акт


Эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болох нь тогтоогдсон акт

#### Эс үйлдэхүй

Иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан хугацаанд биелүүлээгүй буюу шийдвэрлэхгүй орхигдуулсныг хэлдэг.

Хэрэв таны эрхийг захиргааны байгууллага албан тушаалтан ямар нэг хэлбэр (дээр дурдсан)-ээр зөрчсөн бол эрхээ сэргээлгэхээр өмгөөлөгчид хандах нь зүйтэй.

Өмгөөлөгч-таны эрхийг зөрчсөн тухай мэдээллийг аваад юуны түрүүнд хууль бус үйл ажиллагаа явуулсан гэх захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргана.




Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг ГОМДОЛ гэнэ.

Таны гаргасан гомдлыг дээд шатны байгууллага, албан тушаалтан 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд ийнхүү хянан шийдвэрлэж байгааг захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэнэ. Дээд шатны байгууллага албан тушаалтан гомдлыг хянаж үзээд:

- ◆ Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх;
- ◆ Маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох;
- ◆ Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах гэсэн гурван төрлийн шийдвэрийн аль нэгийг гаргана.

Хэрэв дээд шатны байгууллага албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл эсхүл тэр шийдвэр нь хэрэгжихгүй бол та шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.



Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас иргэдийг хамгаалах, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиг үүрэгтэй.

Та захиргааны хэргийн шүүхэд хандаж нэхэмжлэл гаргасан бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогч болно.

## **Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох**

- 29.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч гэрээний үндсэн дээр аль нэг талыг төлөөлөн оролцож болно.**
- 29.2. Талууд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчийн туслалцаа авч болно.**
- 29.3. Тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн бүрэн эрх нь хууль зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр тодорхойлогдоно.**

*Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*

Иргэн шүүхэд нэхэмжлэл гаргахдаа өмгөөлөгчийн туслалцаа авч байгаа бол түүнтэй гэрээ байгуулна. Гэрээг бичгээр үйлдэж шүүхэд мэдэгдэнэ.

Иргэн та өмгөөлөгчтэй гэрээ байгуулах үед шийдэх ёстой асуудал нь өмгөөлөгчийн эрх ямар хүрээнд байх, мөн түүнчлэн хөлсний хэмжээг тохирох асуудал байна. Захиргааны хэргийн өмгөөлөгчийн үйлчилгээний хөлсийг тодорхойлохдоо өмгөөлөгч тухайн хэрэгт зарцуулах цагаар, нэхэмжилж буй шийдвэрийг хүчингүй болгосноос үүсэх үр дагаварыг тооцох зарчмаар, эсвэл маргааны байдлаас шалтгаалж тооцох зарчим зэргийг баримтална.

## **ХОЁР. ИРГЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТойГООР ЗАХИРГААТАЙ ХАРИЛЦАХ НЬ**

Иргэн ба захиргааны хооронд иргэний эрхээ эдлэхтэй холбоотой харилцаа үүсэхээс гадна иргэд хууль тогтоомж болон захиргаанаас тогтоосон журмыг биелүүлэхтэй холбоотой харилцаанд оролцдог байна. Иргэд заримдаа хууль тогтоомж мэддэггүйгээс, мэддэг ч хэнэггүй хандсанаас эсхүл санаатайгаар захиргааны зөрчил гаргах явдал байдаг.

## **ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ ГЭЖ ЮУ ВЭ?**

**Захиргааны зөрчил гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон журам захиргааны санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлдэг.**

*/Захиргааны хариуцлагын тухай хуулиас/*

Жишээлбэл танхайрах, согтуурах, галт зэвсэг, хутга мэс авч явах зэргийг захиргааны зөрчил гэж үздэг.

Дээрх хоёр тохиолдлоос үзэхэд Болд ба Цэнд захиргаанаас тогтоосон хэм хэмжээг ямар нэг байдлаар зөрчжээ. Өөрөөр хэлбэл хуулиар оногдуулсан хууль сахин биелүүлэх үүргээ биелүүлсэнгүй.

Хэдийгээр Болд ба Цэнд захиргааны зөрчил гаргасан боловч хуулиар заасан, олгогдсон эрх тэдэнд бий.

**Зөрчил гаргасан этгээд дараахь эрх эдэлнэ:**

- 1. Зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох;**
- 2. Нотлох баримттай танилцах;**
- 3. Зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах;**
- 4. Шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах;**
- 5. Хууль зүйн туслалцаа авах;**
- 6. Эрхээ зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах.**

*(Захиргааны хариуцлагын тухай хууль. 9 дүгээр зүйл.)*

Чухамхүү эдгээр эрхээ эдэлж, хэрэгжүүлэхэд Танд Өмгөөлөгч туслах болно.

Нэгэнт захиргааны зөрчил гаргасан учраас түүнийг шалгаж, тогтоох, шийдвэрлэх (хариуцлага хүлээлгэх эсвэл чөлөөлөх) зорилгоор зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг эрх бүхий байгууллагаас явуулна.

Зөрчлийг хянан шалгах ажиллагаанд дараахь ажиллагаа орно.

- ◆ Захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаа
- ◆ Тэмдэглэл хийх
- ◆ Эд зүйл баримт бичиг түр хураах, үзлэг хийх
- ◆ Албадан саатуулах

**Зөрчлийн тухай тэмдэглэл хийх.** (Тэмдэглэлийг амаар гаргасан гомдол, хүсэлт, шаардлага хүлээн авах, зөрчил гаргасан этгээд, хохирогч, шинжээчийг асуух, зохих эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас үзлэг, шинжилгээ хийх, түр болон албадан саатуулах, эрүүлжүүлэх, эд зүйл бичиг баримтыг түр хураах, буцааж олгох зэрэг үйл ажиллагааны үед заавал хөтлөх ёстой.)

Зөрчлийн тухай тэмдэглэл

- ◆ Гарсан он, сар, өдөр, цаг
- ◆ Овог нэр, хаяг, эрхэлсэн ажил
- ◆ Зөрчлийн байдал
- ◆ Учруулсан хохирол
- ◆ Захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн холбогдох заалт
- ◆ Хохирогч болон гэрчийн нэр, хаяг
- ◆ Зөрчил гаргасан этгээдийн нэр хаяг

Тэмдэглэл үйлдсэн албан тушаалтан, зөрчил гаргасан этгээд, хохирогч, гэрч гарын үсэг зурна.

**Эд зүйл, баримт бичиг түр хураах.** Захиргааны журмаар албадан саатуулах, биед буюу эд зүйлд үзлэг хийх үед шаардлагатай гэж үзвэл зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, баримт бичгийг түр хураан авч болно.

Эд зүйл, баримт бичгийг хураасан албан тушаалтан тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцах ёстой бөгөөд хэрэв

энэ үүргээ биелүүлээгүй бол иргэн учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

---



**Захиргааны зөрчил гаргагчийн биед эсхүл эд зүйлд үзлэг хийх.** Хуульд захиргааны зөрчил илэрсэн буюу гарсан байж болох хангалттай үндэслэл, сэжиг байгаа бол түүний ул мөр, нотлох баримт олох, энэ талаарх ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах зорилгоор зөрчил гарсан газар, эд зүйл, бичиг баримт, гаргасан этгээдийн биед үзлэг хийж болохоор заажээ. Биед болон эд зүйлд үзлэг хийх нь захиргааны урьдчилан сэргийлэх шинжтэй албадлагын арга хэмжээ бөгөөд зарим үед үзлэг хийлгэх гэж буй иргэн ямар нэг зөрчил гаргаагүй тохиолдол ч байдаг. Тиймээс үзлэг хийх гэж байгаа этгээдээс (ийм эрхтэй этгээд нь цагдаа, хилийн цэрэг, гааль, иргэний агаарын тээврийн болон хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь л байна) чухам ямар үндэслэл сэжиг байгаа учраас үзлэг хийх гэж байгаа шалтгааныг тодруулж болно. Мөн ийм үзлэг хийж байгаа ажиллагаанд хөндлөнгийн гэрчийг заавал байлцуулах ёстойг шаардаж болно. Эд зүйлд үзлэг хийх гэж байгаа бол эзнийг нь байлцуулах бөгөөд хэрэв ийм боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан эд зүйлд үзлэг хийж болно.



**Захиргааны журмаар албадан саатуулах.** Зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэх үед шаардлагатай гэж үзвэл зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар албадан саатуулж болно. Ингэж албадан саатуулах эрхтэй этгээд нь сумын Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах байдаг. Үүнээс өөр албан хаагч нар ямар нэг байдлаар захиргааны журмаар албадан саатуулах эрхгүй бөгөөд хэрэв тэгвэл хууль бус үйлдэл болно.

Энд нэг зүйлийг тодруулахад албадан саатуулж буй явдал бол шийтгэж байгаа явдал биш бөгөөд зөрчлийг хянан шалгах явцад хийгдэж буй арга хэмжээ гэдгийг ялгаж ойлгох ёстой юм. Албадан саатуулах хугацааг хуульд гурван янзаар тогтоож, саатуулах үндэслэлийг тогтоожээ.

1. Зөрчил гаргасан этгээдийн хувийн байдлыг тогтоох зорилгоор түр саатуулж болно. Ингэж саатуулах хугацаа нь 6 цагаас илүүгүй байна.
2. Зөрчил гаргасан этгээдийг ноцтой хор уршиг бий болгоход хүргүүлэхгүй байх зайлшгүй шаардлагатай тохиолдолд харьяалах шүүхэд албан ёсоор мэдэгдэж түүнийг 72 цаг хүртэл хугацаагаар захиргааны журмаар албадан саатуулж болно. Захиргааны журмаар албадан саатуулах хугацаа 72 цагаас илүүгүй.


3. Улсын хилийн дэглэм зөрчигчийн хувийн байдлыг нотлох баримт бичиггүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгээр 10 хоног хүртэл хугацаагаар саатуулж болно.

Аль ч тохиолдолд саатуулагдсан үед хаана, ямар газар, ямар албан тушаалтны мэдэлд байгааг зөрчил гаргасан этгээд болон түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Танай хүнийг саатууллаа шүү



Ийнхүү захиргааны зөрчлийг шалгах арга хэмжээ авсны дараа эрх бүхий этгээд захиргааны зөрчил гаргасан этгээдэд шийтгэл хүлээлгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Захиргааны зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий этгээдэд Засаг дарга, цагдаагийн ажилтан, улсын байцаагч, байгаль хамгаалагч, хилийн ажилтан гээд 10 этгээд хамаарах бөгөөд шийдвэр гаргахдаа нэг бол захиргааны шийтгэл хүлээлгэх эсвэл захиргааны хариуцлагаас чөлөөлөх үндэслэл байвал чөлөөлнө. Энэ хоёр шийдвэрээс гадна хэрэв захиргааны зөрчил гэмт хэргийн шинжтэй бол мөрдөн байцаах байгууллагад шилжүүлдэг.





Захиргааны шийтгэл хүлээлгэсэн бол

- ◆ Торгуулийн хуудас (5000 төгрөгөөс доош)
- ◆ Шийтгэл (торгуулийн хуудаснаас бусад)

Эдгээрээс хамгийн хүнд нь захиргааны журмаар баривчлах шийтгэл болно. Түүнийг шүүгч, сумын Засаг дарга хоёр л хүлээлгэх эрхтэй.

Захиргааны шийтгэл хүлээлгэсэн тохиолдолд хэрэв буруу гэж үзвэл дээд шатны байгууллага, албан тушаалтанд шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй байдаг (ЗХТХ-ийн 19.2). Дээд шатны байгууллага, албан тушаалтан нь 10 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэх ёстой байдаг. Хэрэв дээд шатны байгууллагын шийдвэрийг зөвшөөрөхгүй бол харьяа шүүхэд гомдол гаргаж болно.

## 1.5 ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХИЙГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Иргэд өмгөөлүүлэх эрхээ эдлэхийн тулд юуны өмнө өмгөөлөх болон өмгөөлүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан дүрэм, журмыг зохих хэмжээнд мэдэх хэрэгтэй болно. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Өмгөөлөх байгууллагаас өмгөөллийн өмгөөлөгч болон өмгөөлөх үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам гаргах бөгөөд дүрэм, журмын заалт нь зөвхөн өмгөөлөх үйл ажиллагаа эрхэлж байгаа өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой төдийгүй тэднээс хууль зүйн туслалцаа зөвлөгөө авч байгаа үйлчлүүлэгчийн эрх ашигт хамааралтай зүйл болно.

Монголын өмгөөлөгчдийн холбооноос гаргасан дараах дүрэм, журмууд нь өмгөөлөгч болон үйлчлүүлэгчийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх нийтлэг үндэслэл болно.

Дүрэм гэдэг нь байгууллагын үйл ажиллагааны зорилго, эрх, үүрэг, зохион байгуулалтын бүтэц, бусад байгууллагатай харилцах зарчмыг тодорхойлсон баримт бичиг мөн.

- а. **Монголын өмгөөлөгчдийн холбооны дүрэм.** (МӨХ-ны 1995 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн хурлаар баталж, 2000 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн МӨХ-ны Ерөнхий бага хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан) Энэ дүрмээр Монголын өмгөөлөгчдийн холбооны (цаашид МӨХ гэнэ) үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, бүтэц зохион байгуулалт, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, өмгөөлөгчийн эрх, үүрэг, МӨХ-ны харъяа аймаг, нийслэлийн зөвлөлийн бүтэц, эрх хэмжээ, санхүүжилт, өмгөөлөгчийн хөдөлмөр, хөдөлмөрийн хөлсийг зохицуулах, МӨХ-ны гишүүнийг шагнаж урамшуулах, тэдэнд сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг зохицуулсан байна.
- б. **Монголын өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм.** (2003 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн МӨХ-ны их хурлаар баталсан) Энэ дүрмийн агуулга нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад өмгөөлөгчийн зан үйлийг тодорхойлох, хууль дээдлэх,

шударга, энэрэнгүй байх зарчмыг бататгахад чиглэгдэнэ. Дүрмээр өмгөөлөгчийн ёс зүйн үндсэн хэм хэмжээ, үйлчлүүлэгчтэй харилцах, өмгөөлөгчийн цээрлэх зүйл, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ба баривчлах, урьдчилан хорих байгууллага, шүүх байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчидтой харилцах, өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйг хэрэгжүүлэх асуудлыг зохицуулна.

- в. **Өмгөөлөгчийн сахилгын зөвлөлийн дүрэм.** (Хууль зүйн сайдын 1996 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 68 тоот тушаалаар баталсан) Дүрмээр хууль тогтоомж, өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай маргааныг магадлан шийдвэрлэх МӨХ-ны дэргэдэх “Сахилгын зөвлөлийн” үйл ажиллагааг зохицуулна.

Журам нь тодорхой үйл ажиллагаанд баримтлах дэг, горимыг тогтоосон баримт бичиг юм.

- а. **Өмгөөлөгч цагдан хорих, баривчлах, хорих ангид нэвтэрч сэжигтэн, яллагдагч шүүгдэгч, хоригдол болон баривчлагдсан хүнтэй уулзаж хууль зүйн тусалцаа үзүүлэхэд мөрдөх журам.** (Хууль зүйн сайдын 1998 оны 4 дүгээр сарын 9 –ний өдрийн 83 тоот тушаалын хавсралт) Монгол Улсын Үндсэн хууль, ЭБШХ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, захиргааны хариуцлагын тухай хуулиудын зохих зүйлд заасан дагуу өмгөөлөгчөөс сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдол болон баривчлагдсан хүний өмгөөлүүлэх эрхийг хангах, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн хамгаалах зорилгоор дээр дурьдсан газруудад нэвтэрч уулзахад энэхүү журам үйлчилнэ.
- б. **Өмгөөлөл эрхлэх эрх бүхий гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа явуулах журам.** (Хууль зүйн сайдын 1998 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 113 тоот тушаалын хавсралт) Өмгөөллийн тухай хуулийн зохих зүйлд заасан дагуу өмгөөлөл эрхлэх эрх бүхий гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх болон түүнтэй холбогдсон бусад харилцааг энэ журмаар зохицуулна.

- в. **Өмгөөлөгчдөд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, чөлөөлөх, хасах журам.** (Хууль зүйн сайдын 1995 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 25 тоот тушаалын хавсралт) Өмгөөллийн тухай хуулийн дагуу өмгөөлөгчөөр ажиллах хүнд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, чөлөөлөх, хасах асуудлыг энэхүү журмаар зохицуулна.
- г. **Хоригдол өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авсны хөлс төлөх журам.** (Хууль зүйн сайдын 1996 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 201 тоот тушаалын хавсралт) Шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих ял эдлэж байгаа хоригдол эрх ашгаа хамгаалуулахаар өмгөөлөгч хүсвэл энэ журам үйлчилнэ.
- д. **Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний жишгийг тогтоох, зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайланг гаргах журам.** (Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 69 тоот тушаалын хавсралт) Шүүхийн тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийн зохих зүйлд заасан төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, тайлан тооцоо гаргахад энэ журам үйлчилнэ.

### “ӨМГӨӨЛЛИЙН НУУЦ”

---



Та нэгэнт өмгөөлөгч сонгон авсан бол түүнээс цэрвэх, болгоомжлох хэрэггүй. Өмгөөлөл шаардлагатай болсон асуудлаараа ний нуугүй ярилцаж, санаж бодож байгаа зүйлээ илэн далангүй яриарай. Таны ярьсан тэр бүх зүйл нь өмгөөлөгчөөс өмгөөлөгчийн үйл ажиллагааг таны хууль ёсны ашиг сонирхлын

төлөө үр бүтээлтэй явуулахад маш их хэрэг болдог. Өмгөөлөгч маань миний ярьсан зүйлийг өөр хүнд ярьж тэр нь эргээд надад муугаар нөлөөлнө гэж тээнэгэлзэх хэрэггүй. Өмгөөллийн нууц хуулиар хамгаалагдсан байдаг. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ итгэмжлэн ярьсан зүйлийг задруулахгүй байх ёс зүйн төдийгүй хуулиар үүрэг хүлээдэг.

Хэрэг маргааныг шийдвэрлэхэд нэн чухал мэдээллийг та өмгөөлөгчдөө итгэж өгөөгүйгээс болон таны хэрэг танд ашиггүйгээр шийдвэрлэгдэх тохиолдол гарч болзошгүй гэдгийг та бүү мартаарай.

### “ӨМГӨӨЛӨГЧ МААНЬ ОЛДДОГҮЙ”



Өмгөөлөгч бүхэн “авралын од” биш. Үйлчлүүлэгчийнхээ төлөө чин сэтгэлээсээ анхаарал халамж тавьж, түүний хууль ёсны ашиг сонирхлын төлөө хуулийн хүрээнд чадах бүхнээ хийж, тэдний хайр хүндэтгэлийг хүлээсэн мэргэжлийн ур чадвараа гайхуулсан, ёс зүйг эрхэм чанараараа дээдэлсэн өмгөөлөгчид олон бий. Гэвч үйлчлүүлэгчийнхээ итгэл найдварыг хөсөрдүүлсэн, өмгөөллийн хөлс авчихаад ор сураггүй алга болчихсон эсхүл эсрэг сонирхолтой талтай “хамтран ажиллаж” таныг “гол гаргачихсан” тохиолдол гарч болзошгүйг үгүйсгэхийн аргагүй. Ийм нөхцөл үүсэхэд та хэнд, хаана хандах вэ? гэвэл аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн даргад бичгээр гомдол гаргах ёстой. Мөн монголын өмгөөлөгчдийн холбооны удирдлагад шууд хандаж болно. Өмгөөлөгч нарт сахилгын ямар арга хэмжээ авдагийг өмнө дурьдсан билээ. Өмгөөлөгч хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлдэг болгоход таны шулуун шударга зарчимч шаардлага их тус болох нь дамжиггүй.

## “ӨМГӨӨЛӨГЧ ХӨЛСНИЙ ЭТГЭЭД БУС ХУУЛЬЧ”

---



Та хэрэв гэм буруутай бол түүндээ тохирсон зэмийг хуулийн дагуу хүлээх нь нийгмийн шударга ёсны илрэл юм. Гэвч өмгөөлөгчтэйгээ “хуйвалдан” ямарч хамаагүй үнэ цэнээр хэргийн нотлох баримтыг зохиомлоор үйлдэх эсхүл түүнээр зуучлуулан хуульчдад хахууль өгч хариуцлагаас мултрахыг санаархах нь таныг төдийгүй өмгөөлөгчийг адил гэмт хэрэг үйлдэх замд оруулж буй хэрэг болно. Өмгөөлөгчөөсөө ийм зүйл хүсвэл тэрээр танд эрс шулуухан үгүй гэсэн татгалзсан хариулт өгөх ёстой төдийгүй таныг өмгөөлөхөөс татгалзах ёс зүйн хатуу зарчимтай. Энэ нь өмгөөлөгч мэргэжлийн гэдгээс үүсэлтэй төдийгүй өмгөөллийн үйл ажиллагааны явцад гагцхүү хууль ёсны арга хэрэглүүрийг хэрэглэх талаар өмгөөлөгчид хуулиар хүлээлгэсэн үүрэгтэй шууд холбоотой юм.

Захиргааны хэргийн дагнасан шүүхийн үйл ажиллагаа 2004 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлсэн юм.

## БҮЛЭГ 2

### ТА ТӨЛБӨРИ Н АД АРГҮ Б Л ХУУЛ ЗҮ Н ТУСЛАЛ АА ХЭРХЭН А АХ Э?

- 2.1 Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх төрөөс санхүүжүүлсэн өмгөөллийн туслалцаа.
- 2.2 Өмгөөлөгчдийн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа
- 2.3 Төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авах бусад боломж

Өмнөх бүлэгт өмгөөлүүлэх эрх түүнд холбогдох хууль тогтоомжийн талаар авч үзсэн бол энэхүү бүлэгт төлбөрийн чадваргүй иргэн өмгөөлүүлэх талаар хуулиар олгогдсон эрх, түүнийг хүртэх боломжууд болон хууль зүйн туслалцааг цаг алдалгүй авахад тус дөхөм болохуйц мэдээллүүдийн талаар өгүүлэх юм.

## 2.1 ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ТӨРӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ӨМГӨӨЛЛИЙН ТУСЛАЛЦАА

Нийгмийн сөрөг үзэгдэл буюу гэмт хэрэг зөрчлийн цаана ямагт хэн нэгний эрх ашиг хөндөгдөж байдаг.

Эрх нь зөрчигдөж ямар нэг хэмжээгээр хохирох, эсхүл өөрийн болчимгүй үйлдлийн улмаас бусдыг хохироон хуулийн хариуцлага хүлээж хохирлыг нөхөн төлөх асуудалтай тулгарах нь хэн бүхэнд амаргүй тусна. Ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст энэ нь хүндээр хүндээр тусна. Хэн нэгэн таны эрхийг зөрчөөгүй байх тохиолдолд ч хуулинд заасан ашиг сонирхлоо хамгаалуулахын тулд өмгөөлөгчөөс туслалцаа авах шаардлага урган гардаг.

**“...Монгол Улсын иргэн өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй”**

*Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг*

Гэтэл төлбөрийн чадваргүй, ядуу хүмүүст дээрх эрхээ эдлэх боломж хязгаарлагдмал байдаг. Өөрөөр хэлбэл наад захын хоол хүнс, хувцас хунар зэрэг анхдагч хэрэгцээгээ хангаж чадахгүй хүмүүст өмгөөлөгч хөлслөх, шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүхийн хураамжид төлөх мөнгө байхгүйгээс тэд эрхээ хамгаалуулах арга замаа олохгүй мухардалд орж, эрх нь зөрчигдөн хохирдог.

Шударга ёсны зарчмын үүднээс ямар ч хүн буруутай тохиолдолд л хариуцлага хүлээлгэнэ. Монгол улсын Үндсэн хуульд тодорхойлсон “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэсэн зарчмын хэрэгжилт нь өмгөөлүүлэх эрх хэрхэн хангагдсанаас шалтгаалдаг. Иймээс өмгөөлөгч авах бололцоогүй, төлбөрийн чадваргүй иргэдэд төрөөс эрх зүйн туслалцаа төлбөргүй үзүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэх нь төрийн зайлшгүй үүрэг юм.


Эдгээрээс үзэхэд төлбөрийн чадваргүй иргэд өмгөөлүүлэх эрх хуулиар олгогдсон байна.



“Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү санхүүжилтийг холбоонд олгох бөгөөд уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.”

*мгөөллийн тухай хууль 21.1. дүгээр зүйл.  
үүхийн тухай хууль 9.4. дүгээр зүйл.*

### Улсын төсвөөс төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлын санхүүжүүлэлт



Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн хөлсөнд сүүлийн дөрвөн жилд улсын төсвөөс төсөвлөн зарцуулсан дүнг дараахь хүснэгтээс харж болно.

	н	Батлагдсан төсөв
1	2002	9,000,000
2	2003	9,000,000
3	2004	12,000,000
4	2005	12,00,0000

ХЗДХ-ийн сайдын 2003 оны 4 дүгээр сарын 16-ны 69 дүгээр тушаалын өмнө дурдсан хавсралтын 2 дугаар зүйлд зааснаар төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлсөн өмгөөлөгчид улсын

төсвөөс дараахь жишгээр хөлс олгохоор тогтоосон байна.

- ◆ Хөнгөн гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 12600 хүртэл төгрөг
- ◆ Хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 21600 хүртэл төгрөг
- ◆ Хүнд гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 28800 хүртэл төгрөг
- ◆ Онц хүнд гэмт хэрэгт холбогдсон хүнийг өмгөөлөхөд 43200 хүртэл төгрөг
- ◆ Иргэний болон захиргааны хэрэгт 43200 хүртэл төгрөг
- ◆ ЭБШ болон ИХШХШ ажиллагааны үе шатуудад өөр өөр өмгөөлөгч оролцсон бол хөлсийг тодорхой хувь хэмжээгээр хуваарилдаг байна.



*Хамгийн том хүү маань зодоонд холбогдоод ганц худагт орчихлоо. Тэр чигээрээ шоронд орчих юмуу. Хоногийн хоолоо яая гэж байгаа хүмүүс яаж өмгөөлөгч авч чадах вэ дээ.*

Тогтмол орлогогүй буюу орлого нь хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүй бол төлбөрийн чадваргүй иргэн гэж тооцдог байна.

**“Өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүйн улмаас байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэнийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэж тооцно.”**

*“Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний жишгийг тогтоох, зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан гаргах журам” ХЗДХ-ийн сайдын 2003 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 69 дүгээр тушаалын 1 дэх хэсгийн 1.3*

Хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинг тодорхойлох тухай Монгол Улсын хуульд зааснаар Засгийн газраас баталгаажих доод түвшинг шинэчлэн тогтоож байдаг бөгөөд Үндэсний статистикийн газрын даргын 2005-03-28-ны 01/33 тоот тушаалаар доорхи хэмжээгээр тогтоогдоод байна.

### Хүн амын амьжиргааны доод түвшинг бүс нутгаар харуулбал

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин төгрөгөөр
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	23200
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. рхон	22600
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	22300
4. Зүүн бүс	1.Дорнод 2.Сүхбаатар 3.Хэнтий	25000
5.Улаанбаатар	1.Улаанбаатар	30000



Өөрийгөө болон гэр бүлээ тэжээх орлого нь дээр дурдсан хэмжээнд хүрэхгүй тохиолдолд өмгөөллийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхтэй байна.

Төлбөрийн чадваргүй болохоо нотлохдоо оршин суугаа нутаг дэвсгэрийн баг, хорооны Засаг даргын тодорхойлолтыг авна.

“Өөрийн төлбөрийн чадваргүй болох тухай оршин суугаа нутаг дэвсгэрийн баг, хорооны Засаг даргын тодорхойлолтыг доорх маягтын дагуу гаргуулж өөрийн өмгөөлөгчид өгнө. “

“Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний жишгийг тогтоох, зардлыг төсвөөс санхүүжүүлэх тайлан гаргах журам”-ын 3 дахь хэсгийн 3.4

### Төлбөрийн чадваргүй иргэний тодорхойлолтын загвар

Төлбөрийн чадваргүй иргэний овог, нэр	Нас, хүйс	ршин суугаа хаяг	Иргэний үнэмлэхний болон регистрийн дугаар	Өрхийн орлогын дүн (тегсгөөр)	Ам бүлийн тоо	Нэг хүнд ноогдох орлого	Тайлбар

.....аймаг, нийслэлийн ..... сум, дүцргийн  
 ..... баг, хорооны иргэн .....овогтой.....нь төлбөрийн  
 чадваргүй болохыг тодорхойлов.

.....сум, дүцргийн.....баг, хорооны Засаг дарга.....  
 овогтой.....

Тамга

Гарын цсэг

200.. оны...ны өдөр

Дээрх тодорхойлолтоо өмгөөлөгч авах тухай өргөдлийн хамт өөрийн оршин суугаа аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн даргад өгнө. Ингэснээр уг зөвлөлөөс танд үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийг томилох болно.

**“Төлбөрийн чадваргүй иргэдэд туслалцаа үзүүлэхээр томилогдох өмгөөлөгчийн ажиллах хуваарийг Холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөл гаргасан байх үүрэгтэй.”**

Өмгөөллийн тухай хуулийн 12, 13 дугаар зүйл

**Томилолт /Загвар/**

Эрцүгийн хуулийн .....зүйлд заасан гэмт хэрэгт  
 холбогдсон.....овогтой.....-ын хууль ёсны эрх  
 ашгийг хамгаалуулахаар өмгөөлөгч .....-ийг хэрэг  
 бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд  
 оруулахаар томилолт олгов.

....оны...сарын ...өдөр

... өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга

Түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд төлбөрийн чадваргүй иргэн өмгөөлөгчгүй тохиолдолд тухайн байгууллагаас Монголын өмгөөлөгчдийн холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөлд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авах үүрэгтэй.

Төлбөрийн чадваргүй гэдэг баримтаа бүрдүүлчихлээ, одоо тэгээд өмгөөлөгчөө хаанаас олох юм билээ дээ?



Миний нэг таньдаг хүүхэд хүнд зодуулж хохироод өмгөөлөгч хөлсөлж авах мөнгөгүй гээд Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс өмгөөлөгч томилуулж авч байсан гэсэн

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлбөрийн чадваргүй иргэд нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

**“Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар бусад нотлох баримтаар тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг Улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө. “**

ИХШХШТХ-ийн 58 дугаар зүйл



Нөгөөх чинь гэрийг маань авчихаад өртгөө өгөхгүй байна аа. Шүүхэд нэхэмжлэл гаргая гэхэд тэмдэгтийн хураамж төлөх мөнгө байхгүй яая даа?

## 2.2 ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ТУСЛАЛЦАА

Өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдэд туслахын тулд сайн дураараа үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэн эрхийг нь хамгаалах нь байдаг.

Түүнчлэн өмгөөлөгч бүр жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх үүрэгтэй байдаг тул үүний дагуу үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа үзүүлдэг.

**“Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах үүрэг хүлээнэ:**

- **өмгөөлөгч жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх”**

*Өмгөөллийн тухай хуулийн 12.3. дугаар зүйл*

Өмгөөлөгчдийн дунд явуулсан судалгаагаар төлбөрийн чадваргүй иргэдэд туслалцаа үзүүлэх боломжтой гэж дийлэнх Өмгөөлөгчид илэрхийлсэн. Эдгээр өмгөөлөгчдийн нэр, хаягийн талаархи мэдээллийг доорх жагсаалтаас үзнэ үү.

### Төлбөрийн чадваргүй иргэдэд зөвлөгөө өгөх өмгөөлөгчдийн талаархи мэдээлэл

	Өмгөөлөгчийн нэр	Ажлын байрны хаяг	Хар яалагдах хууль үйн товчоо	мар төрлийн хэрэгт өмгөөлөл явуулах	Харилцах утас
1	Алигэрмаа Г.	БЗД-ийн шүүх, рокурорын байр 22 тоот	Элч хууль зүйн товчоо	Иргэн, эрүү хулгайн хэрэг	99770712
2	Алтанцэцэг .	СБД-ийн шүүхийн байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Ихэвчлэн иргэний хэрэг	99191370
3	Амаржаргал .	вро-Ази ДС	-	Иргэний хэрэг, захиргааны хэрэг	352009 а

4	Ариунтуул А.	ТҮ арк 407 ШУ Т	Эрхэмж ХХ	Эрүү, иргэний хэрэг, Эрүүгийн хуулийн 145, 14 , 215, 91 дүгээр зүйл, хөдөлмөрийн маргаан.	99165 09
5	Батбаяр Ц.	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэдийн эд хөрөнгө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, зам тээврийн хэрэг	99 37356
6	Баярсайхан С.	СБД-ийн шүүхийн байр	Хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх Шударга журам төв	Иргэний хэрэг, өмчийн маргаан, оюуны өмчийг хамгаалах, эрүүгийн хэрэг	99190645
7	Баярт .	СБД-ийн 2-р хороо Амарын гудамж	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааны чиглэлээр	310921 а 99171290
	Баясгалан .	Тэнгэрийн цаг төв	өлөөт	Иргэний хэрэг, өмчийн эсрэг болон шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	311633 а 99134702
9	Болдбаатар С.	Ц Г-ын хар яа ДХБ газар 100 тоот	Батлоо ирм ХХ	Залилангийн гэмт хэрэг, гэрээний үүргийн биелэлтийг хангах	313530 а 992 6357
10	Болормаа Н.	Т арк 407 ШУ Т	Эрхэмж ХХ	Эрүү, иргэн Эрүүгийн хуулийн 145, 14 , 91 дүгээр зүйл, зээлийн гэрээнээс үүдэлтэй маргаан, гэр бүлийн маргаан г.м	99150249



11	Болортуяа Б.	БГД-ийн шүүхийн хойд байр 50-р одваль	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн, хөдөлмөр, гэр бүл	91147257
12	Борхүү Д.	Билиг ХЗДС-ийн байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	99191006
13	Бөххуяг Н.	СХД ЦХ-ийн байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл		
14	Буянжаргал. Ш	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	ИЭЗ-н гэрээний болон оюуны өмчийн	
15	Ганбаатар Г.	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэний ба эрүүгийн хэрэг	3256 7 а 99767274
16	Ганбат Г.	СБД-ийн шүүх	Шударга журам	Авто тээврийн осол, ЭХ-ийн 215, 96, 91, 147, 146,1 1 г.м	991 0 53
17	Ганзориг Ц.	Нийслэлийн шүүхийн зүүн хойд хаалга	Элч ХЗТ	Эрүүгийн хуулийн 145,126,147,146, 215,14 , 91.1	315122 а 9927 4 4
1	Ганчимэг С.	БЗД-ийн шүүхийн 1-р давхар	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүүгийн хэрэг хулгай, танхай, хүчин , иргэний хэрэг гэр бүл, зээл г.м	45 123 а 99124369
20	Дамдин .	БЗ дүүрэг	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Хулгайн хэрэг	911 0026
21	Долгор .	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	329595 г
22	Долгорсүрэн Д.	СБД	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	99294539

23	Дэмбэрэлдагва Н.	Залуучууд зочид буудал	Хөвсгөл ХЗТовчоо	Эрүү, иргэн Хохирогчийн эрхийг хамгаалах	99096919
24	аргалсайхан Ш.	СБ 5 дугаар хороо Тулга ХХ 409 тоот	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэн хоршоотой холбоотой Аж ахуйн маргаан, захиргааны хэрэг	35022 а 99299571
25	Ихтамир Б.	СБД-ийн шүүхийн байр	Шударга журам төв	Эрүүгийн хэрэг	99744456
26	хагва Ш.	Утсаар холбогдох	Хуулийн ач ХХ	Эрүүгийн хэрэг	365004 а 99137610
27	амжав. Н	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	911954 7
2	инжүүр. Д	Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэг	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	6 7 4 а
29	өнхсуурь Д.	СХД-ийн 19-р хороо авхлант төв	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэний хэрэг, гэрээний маргаан	99255756
30	өнхтуяа .	Т арк 407 ШУ Т	Эрхэмж ХХ	Эрүү, иргэний хэрэг, Эрүүгийн хуулийн 145,146,14 ,1 1, 96, 9 , 155 дугаар зүйл	32 106 а 997321 4
31	өнхтуяа. Т	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэн, эрүүгийн хэрэг Хулгай, дээрэм, булаалт, хүн амины хэрэг	
32	өнхцэцэг Г.	СБД-ийн ЦХ	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэн, эрүүгийн хэрэг хүн амь, хулгай, хүчингийн, залилан	997 900

33	өнх-Эрдэнэ Ц.	Интерлото ХХ -ний хуулийн зөвлөл	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Хөдөлмөр, иргэн, эрүүгийн хэрэг	992 0561
34	өнхбат	Билэгт ХЗДС-ийн байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	91207 13
35	Нямжав .	онголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Зээл тооцоо, үл хөдлөх эд хөрөнгө, орон сууцны маргаан, ашигт малтмалтай холбогдсон маргаан	322212 а 99141760
36	росоо Д.	Утсаар холбогдох	Элч ХЗТовчоо	Захиргаа, иргэний хэрэг Газар, ашигт малтмалын лицензтэй холбоотой, хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, хувийн нууц хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой маргаан	99193620
37	тгон үрэв Т.	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэний хэрэг	91913355
3	тгонцэцэг Д.	БЗД-ийн шүүх, рокурор	Баян зүрх товчоо	Ихэвчлэн эрүүгийн хэрэг, Иргэн, захиргааны хэрэг	4523 2 а 99 17221
39	юунцэцэг С.	Ачлал их дэлгүүр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэн, эрүүгийн хэрэг, газартай холбоотой маргаан	319356 а 99193506

40	үрэвбаатар Д.	ХУД 2 дугаар байр 103 тоот	Зэв консалтинг	Иргэний болон захиргааны хэрэг	311343 а 99257 7
41	С ез А.	УИС-ХЗС	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэний хэрэг	
42	Тогоохүү Б.	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	99 7500
43	Төмөрхүү З.	БЗД-ийн рокурорын байр	Элч хууль зүйн товчоо	Эрүү, иргэн	91167757
44	Төрбат .	Утсаар холбогдох	Илч ХЗ товчоо	Эрүүгийн хэрэг, Авто осолтой холбоотой хэрэг	99145 71
45	Туяа .	БГД-ийн 2-р хороо Сөүлийн гудамж 32-3 тоот	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн, татварын хэрэг	94391 а
46	Түвшинжаргал Э.	Төв шуудангийн ард	д консалтинг ХЗ товчоо	Иргэний хэрэг, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой маргаан	329 21 а 9919 979
47	Түвшинтамир Д.	Бага тойруу 24 2 102 тоот	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэний хэрэг, зээл, зээлийн барьцаа, гэр бүл, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой маргаан	91910 67
4	Түвшинцэнгэл .	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Захиргаа, Арбитрын хэрэг,	99 67403
49	Урангэрэл Т.	ТҮ арк 407 ШУ Т	Эрхэмж ХХ	Эрүү, иргэн, гэр бүлийн хэрэг	91145 35
50	Уянга Д.	ТҮ арк ШУ Т	Эрхэмж ХХ	Эрүүгийн хэрэг ЭХ-ийн 14 дугаар зүйл	99719127

51	Уянгахишиг Г.	БЗД 14 дүгээр хороо Бридж гру ийн байр 409 тоот	Цэц ХЗТ	Иргэн, захиргааны хэрэг. Ихэвчлэн гэрээнээс үүссэн болон гэм хор учруулснаас үүссэн маргаан, татвар, ком анитай холбоотой маргаан	462393 а 99 94455
52	Хатанбаатар .	Зоос гоёл ком анийн 3 давхарт	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Хүн амины, хулгайн дээрийн г.м эрүүгийн хэрэг, иргэд хоорондын харилцаа болон банк ком ани хоорондын харилцаа	99191673
53	Хишигбаатар Б.	өнхийн үсэг ХХ -ний байр	үрхин консалтинг	Иргэний хэрэг. Ихэвчлэн гэрээ	33045 а 95155677
54	Хувцагаан .	БЗД-ийн шүүх 23 тоот	Баянзүрх ХЗ товчоо	Эрүү, иргэн эрүүгийн онц хүнд, хүнд, хүндэвтэр хэрэг Иргэний хэрэг	4523 2 а 99163250
55	Цэдэн .Т	Нийслэлийн рокурорын газарт	Ахмад ХЗ товчоо	Эрүү, иргэн аль алинд нь	99172666
56	Цэрэндолгор .	БЗД-ийн шүүх 1 дүгээр давхар	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Бүх төрлийн хэрэг	45 123 а 99193116
57	улуунбаатар .	БЗД 13 дугаар хороолол Скайтель төв	тгонтэнгэр ХЗ товчоо	Хулгай, хүн амь, авто осол зэрэг эрүүгийн хэрэг, иргэний хэрэг	95252945

5	улуунбат Э.	Налайх дүүргийн шүүхийн байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Бүх төрлийн хэрэг	99319041
59	Шүрэнцэцэг Э.	СБД дугаар хороо ТУ арк 424 тоот	онгол өмгөөлөгч ХХ	Иргэний хэрэг	329206 а 99129275
60	Энхбаяр Д.	Утсаар холбогдох	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэн, захиргааны хэрэг иргэн хуулийн этгээдийн нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээх хэрэг	91914 9
61	Энхсайхан .	Бага тойруу 24 2 дугаар байр 102 тоот	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэн, эрүүгийн хэрэг Гэрээний үүрэгтэй холбоотой маргаан, гэр бүлийн болон өв залгамжлал, залилан, авто осолтой холбоотой хэргүүд	991 2036
62	Энхтайван Х.	Д 1 дүгээр хороо 14-2 тоот	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүүгийн хэрэг	330746 а 91 19444
63	Энхтуяа .	Х Д-ийн шүүх 7 тоот	Энэрэл ХЗ товчоо	Бүх төрлийн хэрэг	343151 а 991 923
64	Энх- д .	Д-ийн цагдаагийн хэлтэс	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэн, эрүү, гэрээ, зээлийн маргаан, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд	99125367
65	Энхтунгалаг Д.	БЗД-ийн шүүхийн 1-р давхар	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, иргэн	91612201

66	Энхбаяр Д.	СХД-ийн байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэний хэрэг Өмчлөх эрх, гэм хор учруулснаас үүсэх үүрэг иргэн болон банк, ББСБ, ХЗХ-ы хоорондын зээл, барьцааны гэрээний маргаан	952553 4 99199639
67	Энхчимэг Н.	Д Үндэсний хүүхдийн музейн хойд хаалга	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Иргэний хэрэг, Газар, хэлцэлтэй холбогдсон маргаан	312171 а 991 7 64
6	Эрдэнэцэцэг Б.	БГД 5 дугаар хороо хороолол 12-61 тоот	Аргумент ХХ	Эрүү, иргэн, захиргаа	6 96 а 99093941 99660322
69	мжирмаа.	онголын өмгөөлөгчдийн холбооны байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүүгийн хэрэгт	99165501
70	рин ил .	ҮЭСТ	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүүгийн хэрэг, хүн амины гэмт хэрэг	991 1233
71	Энхтуяа Б.	БГД-ийн 5 дугаар байр	Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл	Эрүү, гэр бүлийн хэрэг, хөдөлмөрийн харилцаа	9923160

Хөдөө орон нутагт байгаа төлбөрийн чадваргүй хүмүүс өмгөөллийн туслалцаа авахыг хүсвэл дараахь нэр хаяг, утсаар холбогдож өмгөөлөгч томилуулан авах хүсэлтээ гаргах боломжтой юм.

Д/д	Аймаг	Зөвлөлийн даргын нэр	Утас	Тайлбар
1.	Архангай	.Эрдэнэ- чир	0132222206	99745757
2.	Баянхонгор	Д.Уранчимэг	99447544	
3.	Булган	Г.Гочоо	01342233 1 (а)	913461 9
4.	Баян-Өлгий	.Сьезд	9942 146	22462, 23751 Өлгий сумын -р баг, аймгийн даатгалын хэлтэс
5.	Говь-Алтай	Н.Болорчулуун	994 9600	сөн булаг сум, Харзад баг. Өмгөөлөгчдийн зөвлөлийн байр.
6.	Говьсүмбэр	Э.Сайхнаа	99549325	Сүмбэр сумын 2 дугаар баг, рокурорын 4 давхар
7.	Дархан-Уул	.Эрдэнэбаатар	99376574	Дархан сум, 4 дүгээр баг, 22 дугаар хороолол А Б байр
.	Дорноговь	Г.Амгалансуурь	99174691	Сайншанд сум, Аймгийн шүүх, рокурорын байр, 3 давхар
9.	Дорнод	.Энхтуяа	015 222570	995 7151 Хэрлэн сумын 6 дугаар баг 5 дугаар байрны 44 тоот
10.	Дундговь	Д.Даваа	99599505	230 5 Аймгийн рокурорын газар
11.	Завхан	.Содномцэрэн	0146223642 а) 01462224 (г)	99469534 Шүүхийн байр, тагнуулын тасаг
12.	рхон	.Дагва	99353632	Эрдэнэт хот, 5 дугаар хороолол, 23 байшин
13.	Өвөрхангай	.Нямдорж	99329954	
14.	Өмнөговь	И. лонмөнх	99532053	Аймгийн шүүх, рокурорын байр, 1 давхар. 16 тоот
15.	Сүхбаатар	Б.Баярцогт	99519232	Баруун-Урт сум, 1 дүгээр баг, Шүүхийн хуучин байр
16.	Сэлэнгэ	Д.Даваасүрэн	91366617	Атарцэцэг 99499366, 99499436. Сүхбаатар сум, 22-р байр дээд кор ус 1-р давхар өмгөөлөгчдийн зөвлөл
17.	Төв	С.Сувдмаа	99309499	Сум дундын 1, 2 шүүхийн байр
1 .	Увс	. юун	99264372	99452222 ХААН банкны байр
19.	Ховд	Д.Эрдэнэчимэг	99439406	99439531. Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн байр, 25 тоот



### **2.3. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ БУСАД БОЛОМЖ**

2003 онд Нээлттэй Нийгэм Форум болон ХЗДХЯ хамтран төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжийг дээшлүүлэх, эрх зүйн туслалцааны чанар үйлчилгээг сайжруулах, боловсронгуй болгох зорилго бүхий “Эрх зүйн туслалцаа үзүүлэх” төслийг хэрэгжүүлэн, төслийн хүрээнд “Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх төв”-ийг Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймагт байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Сонгинохайрхан дүүрэг, Хэнтий аймаг нь хүн амын нягтрал ихтэй, орон нутгаас шилжин ирэгсдийн суурьшил их, хүн амын амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой хүмүүс олноор амьдардаг зэргийг харгалзан дээрх төвийг байгуулсан.

Эдгээр төв нь тухайн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд өмгөөллийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлдэг. Өөрөөр хэлбэл хэргийн холбогдогч нь аль дүүрэг, орон нутгийн харъяалалтай байгаагаас үл хамаарна.

Энэ төвүүдийн өмгөөлөчид нь орон тооны бөгөөд байнгын ажиллагаатай байдаг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн төвд орон тооны дөрвөн өмгөөлөгч, нэг менежер, Хэнтий аймгийн төвд орон тооны хоёр өмгөөлөгч, нэг менежер ажилладаг.

Төв нь тогтмол үйл ажиллагаа явуулснаар чанартай үйлчилгээ хүн бүрт хүрч чадаж байгаа бөгөөд хэрэг шийдвэрлэлтийг хурдасгаж, бусад шүүх, цагдаа, прокурорын байгууллагын үйл ажиллагааг шуурхай явуулахад дэмжлэг болж, зардлыг багасгаж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Төв нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын байгууллагуудтай байнга үр ашигтай, харилцаа холбоотой ажиллах шаардлагатай гэж үзсэний үндсэн дээр эдгээр байгууллагад гэмт хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгч томилуулж байгаа байдалд судалгаа

явуулах, хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нартай уулзалт зохиох, энэ талаар сар бүр мэдээ авах, (төлбөрийн чадваргүй иргэн холбогдсон ЭХБША-нд өмгөөлөгч оролцуулах журам) батлуулах, өмгөөллийн туслалцааг шуурхай хүртээх, төвийн үйл ажиллагааг эдгээр байгууллагуудад албан ёсоор танилцуулж байх гэх мэт тодорхой арга хэмжээ авдаг.

Төвөөс өмгөөллийн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаа нь дараахь журмаар явагддаг.

1. Төв хэргийг хүлээн авах

- ◆ Төвөөс өмгөөлөгч авах буюу өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргах
- ◆ Өмгөөлөч авах хүсэлт гаргасан иргэний төлбөрийн чадварыг тодорхойлох
- ◆ Хүлээн авсан хэргийг ахлах өмгөөлөгчид шилжүүлэх

2. Хүлээн авсан хэргийг өмгөөлөгчид хувиарлах

3. Хэргийг хүлээн авсан өмгөөлөгчид өмгөөллийн үйл ажиллагаа явуулах

**Төв хэргээ дараах замаар хүлээж авдаг**

- ◆ Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид төлбөрийн чадваргүй иргэн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд өмгөөлөгч томилуулхаар тус төвд хүсэлт гаргана.
- ◆ Сонгинохайрхан дүүрэг эсвэл хэнтий аймагт гарсан гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд төрөл садны хүмүүс төвийн үйл ажиллагааны тухай сурталчилгааны материал болон бусад иргэдээс авсан мэдээллийн дагуу тус төвд өмгөөлөгч авах хүсэлт гаргана.

Дээр дурьдсанаар тус төвд хандсан иргэдийг менежер хүлээн авч тусгай бүртгэлд бүртгэнэ.

**Менежер төвд хандаж буй иргэдээс дараахь зүйлийг тодруулна.**

- ◆ Ямар зорилгоор төвд хандсан
- ◆ Эрүү, иргэн, захиргааны хэргийн аль нь болох
- ◆ Аль дүүрэгт шалгагдаж байгаа
- ◆ Хохирогч эсвэл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нь болох
- ◆ Урьд нь өөр өмгөөлөгчтэй байсан эсэх

**Дээрх зүйлсийг тодруулсаны дараа дараахь шаардлагыг хангасан хэргийг төвд хүлээн авна.**

- ◆ Хүсэлт гаргасан иргэний холбогдон шалгагдаж байгаа хэрэг нь Сонгинохайрхан дүүрэгт үйлдэгдсэн байна.
- ◆ Эрүүгийн хэрэг
- ◆ Гэмт хэрэг үйлдсэн болон гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн яллагдагч, шүүгдэгч төлбөрийн чадваргүй байх.
- ◆ Хамт шалгагдаж байгаа хүмүүсийн хооронд сонирхлын зөрчилгүй байх.

**Дараахь хэргүүдийг төв хүлээн авахаас татгалзана.**

- ◆ Иргэний болон захиргааны хэрэг
- ◆ Гэмт хэрэг үйлдсэн болон гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн яллагдагч, шүүгдэгчээс бусад хүнийг төв хүлээн авахгүй.
- ◆ Төлбөрийн чадвартай-Сорилын дагуу төлбөрийн чадвартай болох нь тогтоогдвол төв хүлээн авахаас татгалзана
- ◆ Харьяаллын бус-Сонгинохайрхан дүүргээс бусад дүүрэгт үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа этгээдүүд хоорондоо сонирхлын өрчилтэй бол төв зөвхөн нэгийг нь өмгөөлнө. Бусдыг нь МӨХ руу шилжүүлнэ.

Менежер хүлээн авахаас татгалзсан хэргийн татгалзсан шалтгааныг төвд хандсан иргэнд тайлбарлан өгч зарим тохиолдолд хууль зүйн зөвөлгөөг өгөх буюу бусад холбогдох байгууллагуудад шилжүүлнэ.

- ◆ Иргэний болон захиргааны хэрэг, хохирогч, харъяалын бус хэрэгт төлбөрийн чадвартай иргэнийг нь өөр өмгөөлөгч авахыг зөвөлж, төлбөрийн чадваргүй иргэнд нь зөвлөгөө өгөх буюу МӨХ, Хохирогчийн эрх ашгийг хамгаалах төв, Клиник төвүүдэд шилжүүлнэ.
- ◆ Төлбөрийн чадвартай-өөр өмгөөлөгч авахыг зөвлөнө.
- ◆ Сонирхолын зөрчилтэй-МӨХ-нд шилжүүлнэ.

Төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн тусалцаа үзүүлэх шийдвэр гаргахдаа тусгайлан тогтоосон сорилыг баримталдаг.

## Төлбөрийн чадварыг тогтоох сорил

Өргөдлийн дугаар

Огноо

Овог нэр

Оршин суух хаяг

Эрхэлсэн ажил, хаяг, утасны дугаар

Сарын орлого

алин	Өргөдөл гаргагч	Өрхийн бусад гишүүний нийт орлого	Нийт
Тэтгэвэр, тэтгэмж хувирааа аж ахуй эрхэлсний орлого Бусад орлого Нийт			

### Хөрөнгө

Үл хөдлөх хөрөнгө			
Хадгаламж Бусад			

### Суутгал

Эрүүл мэндийн даатгал			
Нийгмийн даатгал Шүүхийн шийдвэрийн дагуу төлдөг тэтгэмж Түрээсийн зардал Сургуулийн төлбөр Сар бүр төлөх бусад төлбөрүүд рон сууц, цахилгаан, утас.. Нийт суутгал			

*Нийт сарын цэвэр орлого=орлого+хөрөнгө-суутгал=*

*Нийт дүн=нийт сарын цэвэр орлого / ам бцлийн тоо=*

*Дээр дурьдсан миний цалин, орлого, хөрөнгө, зарлагын тухай мэдцүлэг нэн, зөв, бүрэн гүйцэд бичигдсэн. Дээрхи мэдцүлэг худлаа нь тогтоогдсон тохиолдолд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүцүлэхийг зогсоох бөгөөд эрх зүйн туслалцаатай холбоотой гарсан бүх зардлыг хариуцаж төлөх болно.*

*Өргөдөл гаргагчийн гарын үсэг:*

*Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүцүлэх эсэх-Тийм/үгүй*

*Шийдвэр:*

## **НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ ЗАРЛАГА**

### **Хүнсний зүйл**

**53056**

Мах, махан бүтээгдэхүүн  
Гурил, гурилан бүтээгдэхүүн  
Сүү цагаан идээ  
Будаа  
Чихэр, жимс  
Төмс, хүнсний ногоо  
Архи, дарс  
Тамхи  
Хүнсний бусад бүтээгдэхүүн

### **Хүнсний бус бараа бүтээгдэхүүн**

**39506**

Бөс бараа  
Бэлэн хувцас  
Гутал  
Соёлын бараа  
Гэр ахуйн бараа  
Эм, эрүүл ахуй, гоо сайхан  
Түлш  
Барилгын засвар материал  
Бусад бараа

### **Таваарын бус зарлага**

**34250**

Тээвэр холбоо  
Орон сууц, нийтийн аж ахуй

Ахуйн үйчилгээ  
Сургалтын төлбөр  
Эрүүл мэндийн төлбөр  
Татвар хураамж  
Бусад

<b>Хадгаламж</b>	<b>1434</b>
<b>Бусдад өгсөн бэлэг</b>	<b>2794</b>
<b>Нийт</b>	<b>131040</b>
<b>1 хүнд</b>	<b>30474</b>

**Сонгинохайрхан дүүргийн төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх төвийн хаяг**

СХД “Өнөр” хороолол 17 дугаар хороо Монгол даатгал компанийн байр. 2 дугаар давхар

Харилцах утас 682261

Тус төвийн өмгөөлөгчдийн нэрс

С.Юмжирмаа, Н. Одонтуяа, Г. Ганбаатар,

Ц. Мөнхэрдэнэ

Төвийн менежер Б. Лхамсүрэн

Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх Хэнтий аймаг дахь төвийн өмгөөлөгчид тус аймагт гарсан эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид эрх зүйн туслалцаа үзүүлдэг.



**Хэнтий аймгийн төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх төвийн хаяг**

Хэнтий аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн байр

Харилцах утас: 23495

**Тус төвийн өмгөөлөгчдийн нэрс:**

Г.Цэвэлмаа, Ж.Сайхантуяа

Төвийн менежер: Б. Эрдэнэбат

## БҮЛЭГ 3

### ХУУЛ ЗҮ Н ТУСЛАЛ АА А АХ БУСАД Б Л М УУД

- 3.1 Төрийн байгууллагаас авах хууль зүйн мэдээлэл болон өргөдөл, гомдолоо хэрхэн шийдвэрлэх вэ?
- 3.2 Хууль зүйн линикээс үзүүлэх хууль зүйн туслалцаа
- 3.3 Төрийн бус байгууллагуудаас үзүүлэх хууль зүйн туслалцаа
- 3.4. Хууль зүйн туслалцаа үзүүлэх шинэлэг хэлбэрүүд

Та энэ бүлгээс хууль зүйн туслалцаа авч болох байгууллагын танилцууллага, асуудлын чиглэл, хаяг, холбоо барих утас зэрэг мэдээлэлтэй танилцах болно.

### **3.1 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВАХ ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ӨРГӨДӨЛ ГОМДЛОО ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ВЭ?**

Иргэд өөрт шаардлагатай байгаа мэдээллийг хайх, хүлээн авах нь төрийн байгууллага, албан тушаалтан болон бусад газар санал, гомдол гаргах, хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалах, түүнийг хэрэгжүүлэх үндэслэл болдог. Амьдралд хамгийн түгээмэл тохиолддог хүндрэлтэй зүйлийн нэг нь иргэд хуулийн байгууллагуудаас хэрэгтэй мэдээллээ авах явдал байдаг. Ихэнх тохиолдолд иргэд хүссэн зүйлээ тийм хялбар олж авч чаддаггүй ямар нэг бэрхшээлтэй тулгардаг. Энэ үед иргэд хэнд хандах, тэд ямар эрхтэй болохоо тэр бүр мэддэггүйгээс болж эрх ашиг нь зөрчигдөхөд хүрдэг. Иймд иргэдээс тавьж буй санал, хүсэлт, шаардлагыг хүндрэл, чирэгдэлгүй шийдвэрлэх, иргэд болон хуулийн байгууллагын үйл ажиллагааг ойртуулах, харилцан ойлголцол бий болгох, тэдний эрх ашиг, сонирхлыг хангах явдал нь хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл болдог.

Иргэд эрүү, иргэн, захиргааны хэрэгт оролцогч болж өөрөөр хэлбэл гэмт хэрэгт сэжиглэгдсэн, хохирогчоор тогтоогдсон эсвэл иргэний хариуцагч иргэний нэхэмжлэгч гэх мэтээр эрх зүйн харилцаанд оролцож байгаа тохиолдолд шүүх, хуулийн байгууллагаас өөрт хамааралтай мэдээлэл олж авах хэрэгтэй болно.

2002 онд шүүхэд мэдээлэл, лавлагааны алба ажиллуулах тухай Монгол улсын шүүхийн ерөнхий Зөвлөлийн тогтоол гарч анхан, давж заалдах, хяналтын шатны бүх шүүхүүдэд иргэдэд мэдээлэл лавлагаа өгөх төвүүд ажиллаж эхэлсэн байна. Энэ төвүүдийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь тухайн шүүхэд хянан шийдвэрлэж байгаа эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар хэргийн оролцогчдод болон шүүхэд маргаанаа шийдвэрлүүлэхээр хандагчдад шаардлагатай мэдээллийг өгөх, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах, шүүн таслах ажиллагааг гадны нөлөөллөөс ангид байлгах, хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд туслах зорилготой байна. Шүүхийн мэдээлэл, лавлагааны төв нь иргэдэд аль болох ойр, чирэгдэлгүй үйлчлэх ёстой бөгөөд шүүх хурлын хуваарь, шүүхэд гаргах нэхэмжлэлийн бүрдүүлэлт



загвар, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх явц дахь нэхэмжлэгч, хариуцагч, хэргийн бусад оролцогчийн эрх, үүрэг, шүүхэд өргөдөл хүлээн авах цагийн хуваарь, Ерөнхий шүүгч болон шүүгчдийн иргэдийг хүлээн авах цагийн хуваарь, Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6,18,19 дүгээр зүйл, Шүүгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл /Шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйл/, шүүхээр шийдвэрлэж байгаа хэргийн тойм, ял шийтгэл хүлээсэн байдлын тухай товч тоймын талаар мэдээлэл өгдөг.

### **УЛААНБААТАР ХОТОД БАЙДАГ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШҮҮХҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА ӨГӨХ ТӨВҮҮДИЙН ХАЯГ:**

#### **Улсын дээд шүүхийн мэдээлэл лавлагааны төв**

*Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүцрэг, Хувьсгалчдын гудамж, Улсын Дээд Шүцхийн байр. Утас: 261698*

#### **Нийслэлийн шүүх**

*Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүцрэг, Нийслэлийн шүцхийн байр. Утас: 320791*

#### **Сүхбаатар дүүргийн шүүх**

*Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүцрэг, Нэгдсэн Үндэсний гудамж, Сүхбаатар дүцргийн шүцхийн байр. Утас: 320747*

#### **Баянгол дүүргийн шүүх**

*Хаяг: Улаанбаатар, Баянгол дүцрэг, Замчдын-3 гудамж, Баянгол дүцргийн шүцхийн байр.  
Утас: 326586*

#### **Чингэлтэй дүүргийн шүүх**

*Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүцрэг, Чингэлтэй дүцргийн шүцхийн байр. Утас: 320236*

#### **Баянзүрх дүүргийн шүүх**

*Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүцрэг, гудамж, Баянзүрх дүцргийн шүцхийн байр. Утас: 450329*

#### **Хан-Уул дүүргийн шүүх**

*Хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүцрэг, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүцргийн шүцхийн байр.  
Утас: 341891*

## **Сонгинохайрхан дүүргийн шүүх**

*Хаяг: Улаанбаатар, Сонгинохайрхан дүцрэг, 1 дүгээр хороолол, Сонгинохайрхан дүцргийн шүцхийн байр.  
Утас: 687596*

Иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах замаар өөрийн болон бусдын хууль ёсны эрхээ хамгаалуулж болно. Энэ нь төрийн байгууллагаас иргэдийн эрх ашгийг хамгаалах нэг хэлбэр болдог.

### **“Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж түүнийгээ шийдвэрлүүлэх эрхтэй”.**

*Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэг*

Иргэд өөрийн болон бусдын эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл ямар ч асуудлаар тодорхой албан тушаалтан, төрийн болон төрийн бус байгууллагад хандан төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар биечлэн өргөдөл, гомдол гаргах эрхтэй. Төрийн байгууллага нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн дээд, дунд, анхан шатны бүх байгууллагыг хэлнэ. Харин албан тушаалтан гэдэгт дээрх байгууллагад сонгууль буюу томилолтоор ажиллаж байгаа улс төрийн, тусгай болон төрийн захиргааны албан тушаалтан хамаарна.

Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх үйл ажиллагаа нь тусгай хуулиар зохицуулагдана. Иймд өргөдөл, гомдол нь ямар агуулга, хэлбэртэй байх тэдгээрийн ялгааг товчхон танилцуулья.

Улс нийгмийн ач холбогдолтой болон бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг өргөдөл гэнэ. Харин Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийдвэрлэвэл зохих өргөдөл, гомдлыг тухайн асуудлыг харьяалах байгууллагуудад гаргана. Өргөдөл нь хүсэлт, санал, мэдэгдэл, мэдээлэл, шаардлагын зэрэг шинжтэй байж болно.

Өргөдлийн жишээ

**Чингэлтэй дүүргийн шүүхэд**

Улаанбаатар хот

*Садан төрлийн холбоо тогтоолгох тухай*

*Цэцгээ овогтой Баасан миний бие өөрийн эцэг Цэрэнгээрээ овоглуулах хүсэлтэй байна. Намайг нэг настай байхад эцэг эх хоёр маань гэр бцлээ цуцлуулснаар би ээжээрээ овоглох болсон юм. Тэгтэл өнөөдөр 30 жилийн дараа миний өв залгамжлах эрхийн тухай асуудал хөндөгдөж байгаа тул ааваараа овоглуулж Цэрэнгийн хцү болохоо тогтоолгох хүсэлтэй байгаа тул миний гаргасан өргөдлийг хуулийн дагуу шийдвэрлэж өгнө цү.*

Өргөдөл гаргасан

Ц.Баасан

Хаяг: ЧД , 4 дүрээр хороо, 5 дугаар байр 3 тоот

Өргөдөлд шаардлагатай нотлох баримтыг хавсаргав.

Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг гомдол гэнэ.

Гомдолын жишээ

**Нийслэлийн Давж заалдах шатны шүүхэд**

Гомдол гаргах нь:

2005.05.04

Сүхбаатар дүүргийн шүүхийн  
№ 54 тоот шийтгэх тогтоолыг  
давж заалдах тухай

2005 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Сүхбаатар дүүргийн шүүхээр Эрцүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148-ын 2 дах хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн Болд овогтой Батаад холбогдох хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шүүхийн № 54 тоот шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргаж байна. Миний бие Дорж овогтой Сүрэн нь энэ хэргийн хохирогчоор тогтоогдсон бөгөөд шүүгдэгч Б.Батаа нь надаас 2004 оны 11 дүгээр сард 4 сая төгрөг залилан мэхэлж аваад уг мөнгөнөөс 1 сая төгрөгийг одоо болтол төлөөгүй байхад шүүх хорих ялыг үндэслэлгүйгээр тэнсэж Эрцүгийн хуулийг буруу хэрэглэсэн байна. Учир нь Эрцүгийн хуулийн ял тэнсэх заалтад “ гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан” тохиолдолд ял тэнсэж болно гэж заажээ. Гэтэл шүүх үүнийг харгалзан үзэлгүй Б. Батаад хэт хөнгөн ял оногдуулсан тул Сүхбаатар дүүргийн № 54 тоот шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож өгнө үү.

Гомдол гаргасан

Д.Сүрэн

Хаяг; УБ, СБД, 1 дүгээр хороо, Рашаантын 5-9 тоот  
Утас: 99876543

Иргэд шүүх, хуулийн бусад байгууллагууд тэдгээрийн албан тушаалтнуудад зохих журмын дагуу өргөдөл, гомдол гаргахын зэрэгцээ ялангуяа эрүү, иргэний хэрэгтэй холбоотой асуудлаар ХЗДХЯ-ны сайдад хандаж өргөдөл, гомдол гаргаж болдог.

**ХЗДХЯ-ны сайдын иргэдийг хүлээн авах өдөр**

*Даваа гариг бүр 14<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд*

*ХЗДХЯ-ны хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүцрэг, Худалдааны гудамж, 6/1 Засгийн газрын V байр*

*Харилцах утас: Сайдын туслах утас: 261708*



Дээрх байгууллагуудаас гадна таны хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах зорилго бүхий байгууллагын нэг нь Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК) юм. ХҮЭК нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон олон улсын гэрээнд заасан хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах чиг үүрэг бүхий бие даасан хараат бус байгууллага юм. ХЭҮК 2000 онд “Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс”-ын тухай хууль батлагдсанаар байгуулагдсан.

Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн Монгол улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь зөрчсөн гэж үзвэл иргэн дангаар буюу хамтарч хүний эрхийн комисст гомдол гаргах эрхтэй. Гомдлыг монгол хэлээр бичгээр, эсхүл амаар биечлэн гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.

ХЭҮК-т хандаж гомдол гаргаж байгаа тохиолдолд дараах зүйлийг тусгасан байна:

- ◆ Гаргасан гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх;
- ◆ Монгол улсын Үндсэн болон бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн болохыг заах;
- ◆ Гомдол гаргагч өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурсан байх;
- ◆ Гомдолд холбогдож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргасан байна.

Комиссын гишүүн нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэрэг, маргааны талаархи гомдлыг хүлээн авахгүй. Гомдол гаргагч эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн өдрөөс, эсхүл зөрчигдсэн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гомдол гаргана.

**Хүний Эрхийн Үндэсний Комисст хандах хаяг:**

*Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай,  
Засгийн газрийн 11 дүгээр байр, 5 дугаар давхарт  
Харилцах утас: 320284*

Хууль зүйн үндэсний төв нь хууль тогтоомжийн тогтолцоо, хэрэгжилт, уялдаа, үр нөлөөг шинжлэх ухааны үндэстэй судалж, холбогдох асуудлаар төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, төрийн болон төрийн бус байгууллагын захиалгаар хуульчдад мэргэжлийн давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах зорилго бүхий эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны байгууллага юм.

*Хаяг: УБ хот, Чингэлтэй дүцрэг, Сүхбаатарын  
гудамж  
Утас: 315734, 322094  
Факс: 315735*

*Иргэдийг хүлээн авах өдөр: Ажлын өдрүүдэд ажлын  
цагаар. Цайны цаг 13.00-14.00*

### **3.2. ХУУЛЬ ЗҮЙН КЛИНИКЭЭС ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА**

Эрх зүйт төрийг төлөвшүүлж хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн өнөөгийн нөхцөлд хуульчийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлага улам бүр нэмэгдэхийн хэрээр ирээдүйн хуульчдыг бэлтгэх, тэдэнд мэргэжлийн дадал дүй олгох, хууль хэрэглэх чадварыг хөгжүүлэх сургалтын шинэлэг хэлбэрийг бий болгох бодит шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Сургалтын энэхүү шинэлэг хэлбэрийг хууль зүйн клиник сургалт хэмээн нэрлэж 1930-аад оны үеэс дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч эхэлсэн юм. Хууль зүйн клиник сургалт нь хууль зүйн их, дээд сургууль, коллежийн ахлах дамжааны оюутнууд нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх замаар онолын мэдлэгээ практикт ашиглах боломж олгодог.

Монголд анх удаа 1999 онд хууль зүйн клиник сургалт МУИС-ийн Хууль зүйн сургуульд нэвтэрсэн бөгөөд “Хүмүүнлэг” төвийг нээн ажиллуулснаас хойш одоо 10 гаруй хуулийн их сургууль, коллежид оюутнууд үнэ төлбөргүй зөвлөгөө өгдөг клиник төв үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр төвд ахлах, дамжааны оюутнууд эрүү, иргэн, захиргааны эрх зүйн чиглэлээр үнэ төлбөргүй зөвлөгөө өгөхдөө багш нарын удирдлага дор ажилладаг онцлогтой.


Мэргэжлийн өмгөөлөгч хөлслөн авах чадваргүй, эмзэг бүлгийн хүмүүст оюутнууд хууль зүйн туслалцаа үзүүлж байна. Үүнд:

- ◆ Хууль, дүрэм, журам болон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл, лавлагаа өгөх
- ◆ Өргөдөл гомдол, нэхэмжлэл, тайлбар, гэрээ зэрэг бичиг баримт боловсруулж өгөх
- ◆ Таны итгэмжлэлийн үндсэн дээр төрийн болон хуулийн байгууллагад төлөөлөх
- ◆ Хуулийн шинэ заалтуудын талаар тайлбарлах



Хуулийн сургуулийн оюутнаас зөвлөгөө авъя.

Хууль зүйн клиник төвийн оюутнууд зөвхөн сургууль дээрээ иргэдийг хүлээн авахаас гадна аль болох тэдэнд ойртуулах зорилгоор төрийн бус байгууллага, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран гэр хороолол дахь төвүүдэд жижүүрлэн ажиллаж байна.



Хууль зүйн клиник төвүүд дээр сонгон шалгаруулж авсан оюутнууд өмгөөлөл явуулах эрх бүхий удирдагч багшийн удирдлага дор салбар эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшиж өдөр бүр ажлын цагаар жижүүрлэн ажилладаг.

Төвд жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа оюутан тантай уулзаж ярилцсан тухай тэмдэглэл хөтлөн зарим нэг шаардлагатай баримт бичгийг шаардах болно. Үүнд:

- ◆ Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ
- ◆ Гэрээ, хэлцэл
- ◆ Итгэмжлэл
- ◆ Өмчлөх эрхээ гэрчилэх баримт бичиг



- ◆ Тухайн байгууллага албан тушаалтнаас өргөдөл, гомдолд өгсөн хариу мэдэгдэх хуудас.
- ◆ Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагаас гаргасан шийдвэрийн хуулбарууд

Иргэдэд үнэ төлбөхгүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг хууль зүйн клиник төвүүдийн мэдээллийг доор үзнэ үү.

**МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн дэргэдэх хууль зүйн клиник сургалтын “Хүмүүнлэг” төв**

*Хаяг: УБ хот, НҮБ-ын гудамж-17, МУИС-ийн хичээлийн III байрны 2 давхарт 203 тоот.*

*Утас: 310524*

*Факс: 976-11-310524*

*Шуудангийн салбар-46, ш / х 78*

*E-mail: lawclinic@yahoo.com*

*Иргэд хцлээн авах хуваарь:*

*Ажлын өдрүүдэд 10.00.-13.00, 14.00-17.00*

**“Шихихутаг” ХЗДС-ийн клиник сургалтын “Буян” төв**

*Хаяг: Улаанбаатар хот, СБД, ОСТ-ын 6 дугаар хороо МУИС, Япон судлалын төвийн хойно*

*Утас: 318712*

*Факс: 976-11-318712*

*E-mail: buyan\_center@yahoo.com*


**Түшээ ХЗДС-ийн хууль зүйн клиник сургалтын “Түшээ” төв**

*Хаяг: Улаанбаатар хот, Их сургуулийн гудамж-8*

*Утас: 318189*


*Факс: 976-11-320674*

*E-mail: tushee@mol.mn*




**“Отгонтэнгэр” их сургуулийн хууль зүйн клиник сургалтын төв**

Хаяг: Улаанбаатар хот, БЗД, Энх тайвны өргөн чөлөө  
Жуковын гудамж  
Шуудангийн салбар: 51. ш/х 35  
Утас: 453944, 453933  
E-mail: ot\_ouun@magicnet.mn



**“Улаанбаатар-Эрдэм судлал” дээд сургуулийн клиник сургалтын төв**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, ЧД 4 дүгээр хороо,  
Самбуугийн өргөн чөлөө, Улаанбаатар-Эрдэм судлал  
Дээд сургуулийн хичээлийн байр 105 тоот  
Утас: 327889, 99818166  
Факс: 976-11-319111  
E-mail: uberdemsudlal@yahoo.com  
Ажлын хуваарь: Даваа, Лхагва, Баасан: 09<sup>00</sup>-18<sup>00</sup> цаг  
Цайны цаг: 13.00-14.00 цаг



**Иргэдэд хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх  
“Билэг” клиник төв**

*Хаяг №1: Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, Залуучуудыг өргөн чөлөө-7/4, Билиг дээд сургуулийн байранд, 103 тоот.*

*Утас: 322160, 99156967, 99882080*

*Факс: 976-11-321942*

*E-mail: bilig.edul@mongol.net*

*Web page: www.bilig.mn*


*Ажлын хуваарь:*

*Даваа, Лхагва, Баасан: 14<sup>30</sup>-17<sup>30</sup> цаг.*

*Хаяг №2: СХД, 10 дугаар хороо, Зүцнбаян-Уулын 22-1 тоотод орших “Олон нийтэд тцшиглэсэн хццхдийн хөгжил хамгаалал төв”*

*Утас: 306169*

*Ажлын хуваарь: Даваа, Лхагва, Баасан: 14<sup>30</sup>-17<sup>30</sup> цаг.*



**“Хасагт хайрхан” эрх зүй, нийгмийн ухаан дээд сургуулийн клиник**

*Хаяг: Улаанбаатар хот, СБД, 11 дүгээр хороо, 116 дугаар тусгай дунд сургуулийн хуучин байр, 3 дугаар давхар.*

*Шуудангийн салбар: 51. ш/х 35*

*Утас: 353500*

*Факс: 976-11-353500*

*E-mail: purevus@yahoo.com*

**Боловсролын их сургуулийн хэрэглээний эрх зүйн клиник**

*Хаяг: Улаанбаатар хот, БИС-ийн хичээлийн Б байр, 212 тоот*

*Утас: 322705*

*Факс: 976-11-322705*

*E-mail: shss@nstu.edu.mn*

Төлбөрийн чадваргүй иргэдэд мэргэжлийн өмгөөлөгч нар хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ Хүний Эрхийн Үндэсний Комисс, “Урам” төрийн бус байгууллага, бизнес хөгжлийн “Гэр санаачлага” зэрэг төслийн байгууллагууд хууль зүйн мэргэжлийн сургуулиудын багш оюутны багтай хамтран гэр хорооллын иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх төвүүдийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг хотын гэр хороолол дунд байгуулан ажиллуулж байна. Эдгээр төв үйл ажиллагаагаа хаана хэрхэн явуулдаг талаар танд доорх мэдээллийг өгч байна.

2004 оны 3 дугаар сараас эхлэн Хүний эрхийн үндэсний комисс, “Урам” төрийн бус байгууллага, Английн элчин сайдын яам хамтран “Эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа” туршилт төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх 3 төв Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгино хайрхан дүүргийн гэр хорооллын дунд орших Их Британы Хүүхдийг ивээх сангийн “Олон нийтэд түшиглэсэн хүүхэд, хөгжил, хамгаалал” төвийн байранд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Төслийг хэрэгжүүлэхэд МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Шихихутаг” болон “Билиг” сургуулиудын багш, оюутны баг оролцон хууль зүйг зөвлөгөө үнэ төлбөргүй өгч байна.

Энэхүү төвүүдийн хаяг, байршил, ажиллах хуваарийг хүргэе.

**Хууль зүйн зөвлөгөө өгөх нэгдүгээр төв**

*Хаяг: Баянзүрх дүцрэг 16 дугаар хороо, Зэв захын зүцн талд орших, Олон нийтэд тцшиглэсэн хццхдийн хөгжил хамгааллын төв,*

*Утас: 90154950*

*Ажиллах цагийн хуваарь:*

*Даваа, Лхагва, Баасан гаригийн 14.00-17.00 цаг*

*Хариуцсан баг:*

*“Шихихутаг” Хууль зүйн дээд сургууль*

**Хууль зүйн зөвлөгөө өгөх хоёрдугаар төв**

*Хаяг: Чингэлтэй дүцргийн 15 дугаар хороо, Жаргалантын 40 дүгээр гудамж, 0752 тоотод орших Олон нийтэд тцшиглэсэн хццхдийн хөгжил хамгааллын төв*

*Ажиллах цагийн хуваарь:*

*Даваа гариг: 11.00-16.00 цаг*

*Лхагва гариг: 12.00-17.00 цаг*

*Баасан гариг: 14.00-18.00 цаг*

*Хариуцсан баг:*

*МУИС-ийн Хууль зүйн сургууль*

**Хууль зүйн зөвлөгөө өгөх гуравдугаар төв**

*Хаяг: Сонгинохайрхан дүцргийн 10 дугаар хороо, Зүцн баян уулын 22-1 тоотод орших Олон нийтэд тцшиглэсэн хццхдийн хөгжил хамгааллын төв*

*Утас: 306169*

*Ажиллах цагийн хуваарь:*

*Даваа, Лхагва, Баасан гаригийн 14.30-17.30 цаг*

*Хариуцсан баг:*

*“Билиг” Хууль зүйн дээд сургууль*

Олон улсын СНФ байгууллага бизнес хөгжлийн “Гэр санаачлага” төслийнхөө хүрээнд гэр хорооллын иргэд, жижиг бизнес эрхлэгчдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх

төвүүдийг мөн МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудтай хамтран 2004 оны дөрөвдүгээр сараас эхлэн ажиллуулж байна. Үүнд:

**Улаанбаатар хот**

**Яармаг салбар**

*Яармагийн хуучин эцэс, Шуудан холбооны 30 дугаар салбарын байр. Утас: 95154957*

**Шар хад салбар**

*17 дугаар хороо, Цахлай захын буудал, 2 давхар улаан тоосгон байр. Утас: 95254389*

**4 буудал салбар**

*13 дугаар хороо, 4 буудал, Утас: 95255356*

**Баянхошуу салбар**

*Баян хошууны шинэ эцсийн буудал, ХААН банкны 2 давхар. Утас 95255352*

**Толгойт салбар**

*3 дугаар хороо, 65-р сургуулийн урьд төв зам дээрх 24 цагийн дэлгэцрийн 2 давхарт. Утас 95254480*

**Дархан хот**

*Дархан хот дахь бизнесийг дэмжих төв. 9-р баг, хээтэй хороолол, 4-ийн 1 байр, Утас: 24708, факс: 24788*

**Тосгоны салбар**

*1, 2, 3 дүгээр багийн төв, Утас: 351108*

**Захын салбар**

*Дархан хотын татварын хэлтсийн байр, 101 тоот, Утас 35303*

**Эрдэнэт хот**

*Эрдэнэт хот дахь бизнесийг дэмжих төв. Сансар төв. Утас: 28914, факс: 28913*

**Хорооллын салбар**

*Хорооллын эцсийн буудал, “Отгонтэнгэр” худалдааны төвийн 1 давхарт. Утас: 24472*

**Захын салбар**

*Бичил худалданы төвийн урд талын 2 давхар ягаан байр. Утас: 90350036*

**Чойбалсан хот**

*Чойбалсан хот дахь бизнесийг дэмжих төв, Дархан  
цаазат газрын захиргааны байр, 3 давхар 4 тоот.  
Утас: 22572, факс: 22571.*

**Хорооллын салбар**

*4 дүгээр баг “Ногоон оюу” дэлгэцрийн байр,  
Утас: 90582574*

**Захын салбар**

*Шүр захын хашаанд ХХБ-ний зүүн талд.  
Утас: 22573*

### 3.3 ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДААС ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

Үндсэн хууль болон Монгол улсын олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, эрх зүйн туслалцаа зөвлөгөө өгөх нэгэн зууч нь төрийн бус байгууллага байдаг.

Иргэдэд хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө үзүүлдэг ТББ-уудын мэдээллийг доорх жагсаалтаас үзнэ үү..

#### **Хүний эрх хөгжил төв**

Зорилго: Хүн худалдах гэмт хэрэг, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн зөрчлийн асуудлаар зөвлөгөө өгөх

Хаяг: УБ хот Чингэлтэй дүцрэг Чандмань төвийн ард  
(Хуучнаар Лениний музей) модон байшин 2  
давхар

Утас / факс: 976-11-325721

И-мэйл: [chrd@mongolnet.mn](mailto:chrd@mongolnet.mn)

Вэб сайт: [www.owc.org.mn/chrd](http://www.owc.org.mn/chrd)

#### **Хүчирхийллийн эсрэг үндэсний Төв**

Тус төв нь орон нутагт 11, Улаанбаатар хотод болон алслагдсан хоёр дүүрэгт (Налайх, Багануур) салбартай.

Төвийн зорилго:

- ◆ Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийг эсэргүүцэх, үл тэвчих нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх;
- ◆ Хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чадвар бүхий хууль эрх зүйн оновчтой орчинг бүрдүүлэх;
- ◆ Хүчирхийллийг даван туулахад чиглэгдсэн нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгон хөгжүүлэхэд тус тус нөлөөлөн ажиллана.

Хаяг: УБ хот ЧД-ийн Бага тойруу 140-р байр, 1 давхарт  
3, 6 тоот

Утас: 329850; 1903

И-мэйл: [mongolcas@magicnet.mn](mailto:mongolcas@magicnet.mn)

Вэб сайт: [www.ncav.org](http://www.ncav.org)

Иргэдийг хцлээн авах өдөр:

Ажлын өдрүүдэд ажлын цагаар. Цайны цаг 13.00-14.00



## **Эрх чөлөө төв**

Зорилго:

- ◆ Анхан шатны үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө утсаар, интернэтээр, биечлэн өгөх
- ◆ Хуулийн номын сангаар дамжуулж, хууль зүйн ном, мэдээллээр хангана.
- ◆ Танд тусалж чадах хүмүүстэй холбоо тогтооход тань туслана.
- ◆ Шаардлагатай гэж үзвэл интернэт дээр таны зөвшөөрлөөр хэргийн талаар сэрэмжлүүлэг бичнэ.

*Хаяг: Улаанбаатар хот Монголын Залуучуудын холбооны байр 310 тоот.*

*Утас: 321297*

*И-мэйл: ariuna\_liberty@yahoo.com*

*Вейб сайт: www.liberty-center.org.mn*

*Иргэдийг хүлээн авах өдөр:*

*Ажлын өдрүүдэд ажлын цагаар*

*Цайны цаг 13.00-14.00*

## **Олон улсын хүний эрхийн “Эмнести интернейшнл” байгууллагын Монгол дахь салбар**

Зорилго:

- ◆ Тус байгууллага хүний эрхийг хамгаалахдаа бие махбодь, оюун санааны төгс байдал, чөлөөтэй сэтгэн бодох, үзэл бодлоо илэрхийлэх, мөн ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг эрх, эрхчөлөөг ноцтой зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор судалгаа явуулж, бодитой арга хэмжээ, үйл ажиллагаа явуулна. Иргэдийг хүлээн авч хууль эрхийн зөвлөгөө өгнө.

*Хаяг: УБ хот Сүхбаатар дүцрэг, 6 дугаар хороо, Бага тойруу-44.10 тоот*

*Утас: 324705*

*И-мэйл: aimnseye@magicnet.mn*

*Вейб сайт: www.amnesty.mn*

*Иргэдийг хүлээн авах өдөр:*

*Ажлын өдрүүдэд ажлын цагаар.*

*Цайны цаг 13.00-14.00*

### **Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв**

Зорилго:

- ◆ Хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр гарсан Олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар судалгаа хийж, олон нийтэд мэдээлэл өгөх
- ◆ Хүүхдийн гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэж байхаас гадна тэдний эрх зөрчигдсөн эсэхэд зөвлөгөө өгөх
- ◆ Эрх нь зөрчигдсөн хүүхдүүдэд шуурхай туслах зорилгоор лавлах утас ажиллуулж, уг ажиллагаанд өмгөөлөгч, хуульчдын сайн дурын хамтлагийг гэрээний үндсэнд оролцуулах

*Хаяг: УБ хот, Сүхбаатар дүцрэг, Монголын хүүхдийн ордон, 1 давхарт 2 тоот*

*Утас: 328926, 99159268*

*Факс: 976-11-328926*

*Иргэдийг хүлээн авах өдөр:*

*Ажлын өдрүүдэд ажлын цагаар.*

*Цайны цаг 13.00-14.00*

### **Монголын Хүүхдийн эрхийн төв**

Зорилго:

- ◆ Хүүхдийн эрхийн конвенцийн сургалт, сурталчилгаа, хүүхдийн эрх зөрчигдсөн үед зөвлөгөө өгөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх

*Хаяг: УБ хот, Сүхбаатар дүцрэг, 1 хороо, Чингисийн өргөн чөлөө, Авто тээврийн газрын хойд тал, 19 байрны өргөтгөл*

*Утас: 310807*

*Иргэдийг хүлээн авах өдөр:*

*Ажлын өдрүүдэд ажлын цагаар.*

*Цайны цаг 13.00-14.00*

## Монголын эмэгтэйчүүдийн холбоо

Зорилго:

- ◆ Улс төр, нийгмийн амьдрал болон гэр бүл, оюун санааны бүх хүрээнд эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангахуйц хууль эрхийн баталгааг бүрдүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулж, эмэгтэйчүүд, хүүхэд, гэр бүлийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр тэмцлийг зохион байгуулах;
- ◆ Эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомжийн биелэлтэд өөрийн үйл ажиллагаагаар хяналт тавьж, энэ ауудлаар төрийн хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагад санал дэвшүүлэх;
- ◆ Эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжиж ажлын байр бий болгох, орлого нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлж, жижиг зээл олгох зэрэг үйл ажиллагааг явуулах;

*Хаяг: УБ хот Энх тайвны өргөн чөлөө, 50 мянгат, 22 байр, 39 тоот.*

*Утас: 328336*

*И-мэйл: monwofed@magicnet.mn*

*Иргэдийг хцлээн авах өдөр: Пүрэв: 14<sup>00</sup>-17<sup>00</sup>*

## Хүйсийн Тэгш эрхийн төв

Зорилго:

- ◆ Бэлгийн харилцааны хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг, дамжуулан худалдахад өртөгсөд болон хохирогчдод хууль, сэтгэл зүйн зөвөлгөө өгөх, хор уршгийг нээн гаргаж, олон нийтэд таниулах, урьдчилан сэргийлэх
- ◆ Гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг явуулах, хүйсийн тэгш эрхийн талаар төр засгийн бодлого, шийдвэр, хууль зүйн үндсийг бүрдүүлэх, хэрэгжүүлэхэд идэвхитэй нөлөөлөх гэх мэт

*Хаяг: УБ хот Чингэлтэй дүцрэг Эрх чөлөөний талбай, / Хуучнаар Лениний музейн ард/ 2-1 байр.*

*Утас: 311512*

*И-мэйл: gendekegsen@mn*

*Иргэдийг хцлээн авах өдөр:*

*Ажлын өдрүүдэд ажлын цагаар.*

*Цайны цаг 13.00-14.00*

### **Монголын тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоо**

Зорилго:

- ◆ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, сургалт семинар зохион байгуулах
- ◆ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг баталгаажуулах нөхцлийг бүрэн дүүрэн хангасан хуулийн тогтолцоог бүрдүүлэх ба бодлого боловсруулахад идэвхитэй оролцох.

*Хаяг: УБ хот Чингэлтэй дүцрэг, VI хороо, 33 а байр,*

*Утас: 324449*

*И-мэйл: adw@mobinet.mn*

*Вейб сайт: www.ewc.org.mn/adw*

### **Монголын сонсголын согогтой иргэдийн “Шинэ элч” холбоо**

Зорилго:

- ◆ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэлмэрчлэх, хууль тогтоомжийн заалтыг тайлбарлаж өгөх
- ◆ Хууль эрхийн болон ерөнхий боловсролын мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах

*Хаяг: УБ хот Сүхбаатар дүцрэг, 10 дугаар хороо, 29 дүгээр тусгай сургууль, 223 тоот*

*Утас: 368483, 351255, 99672631*

*И-мэйл: mdf\_new\_@yahoo.com*

*Иргэдийг хүлээн авах өдөр:*

*Ажлын өдрүүдэд ажлын цагаар.*

*Цайны цаг 13.00-14.00*

### **Хүүхэд залуучуудын зүйн боловсролын төв**

Зорилго: Хууль эрх зүйн сурталчилгаа, зөвлөгөө өгөх

*Хаяг: УБ хот, Сүхбаатар дүцрэг, 5 шар, Монгол- Болгар*

*Утас: 99114436*

*Иргэдийг хүлээн авах өдөр:*

*Ажлын өдрүүдэд ажлын цагаар.*

*Цайны цаг 13.00-14.00*

### 3.4 ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ШИНЭЛЭГ ХЭЛБЭРҮҮД

Нийгмийн хөгжлийн явц, шинжлэх ухаан, технологийн хөгжилтэй уялдаад өмгөөлөгч урьд нь эрх зүйн туслалцаа, зөвлөгөөг зөвхөн биечлэн өгдөг байсан бол эрх зүйн туслалцаа үзүүлэх шинэ хэлбэрүүд бий болж байна. Тухайлбал, сүүлийн үед утсан харилцааг ашиглан хууль зүйн зөвлөлгөө өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг ашиглан иргэдийн асуултад хариулах зэрэг хэлбэрээр ажиллаж байна.

#### УТСААР ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨГӨӨ

**1933, 1954, 1916, 1939** гэсэн утсуудаар хууль зүйн зөвлөгөө өгч байна.

**1916** *Зөвлөгөө өгөх цаг: 9:00-21:00*

Хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэл: Эрх зүйн нийтлэг асуудлаар (хууль зүйн зөвлөлгөө өгөхдөө илүү “зөвлөмж” гэсэн хэлбэрээр өгөх ба нэмэлт зөвлөгөө, тайлбар шаардлагатай бол доорх хаягаар ирж болно)

*Хаяг: УБ хот, Сүхбаатарын гудамж, 6 “Цэцээ гүн” дээд сургууль, 203 тоот*

*Утасны төлбөр: 1 мин- 400₮*

**1933** *Зөвлөгөө өгөх цаг: 9:00-21:00*

Хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэл: Эрүүгийн хэрэг- хүн амь, хулгай, дээрэм, авто аваарын зэрэг хэрэг. Иргэний хэрэг-гэрээ, өв залгамжлал, үл хөдлөх хөрөнгө, газар ашиглах, эзэмших. Түүнээс гадна утсаар зөвлөгөө авсны дараа илүү гүнзгийрүүлж зөвлөгөө, хууль зүйн туслалцаа шаардлагатай бол холбогдох баримт, нотлох баримтыг үзүүлж танилцуулах, биечлэн уулзах боломжтой.

*Утасны төлбөр: 1 мин- 400₮*

**1954** *Зөвлөгөө өгөх цаг: 9:00-18:00*

Хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэл: Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал, тэдгээртэй холбоотой эрх зүйн асуудал

*Хаяг: Улаанбаатар хот, ЧД, 1 дүгээр хороо, 1 дүгээр 40.000, 8 дугаар байрны 1 тоот*

*Утасны төлбөр: 1 мин- 300₮*

**1939 Зөвлөлгөө өгөх цаг: 9:00-18:00**

Хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэл: Эрх зүйн нийтлэг асуудлаар (хэрэв тухайн асуудлаар шууд зөвлөгөө өгөх боломжгүй бол сайтар судалсны үндсэн дээр утасны дугаараар нь тухайн иргэн рүү эргэж залган нэмэлт тайлбар, зөвлөлгөө өгдөг онцлогтой)

*Утасны төлбөр: 1 мин- 360₮*

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ДАМЖУУЛАН ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ХЭЛБЭР**

Иргэдийн сонирхсон бөгөөд тэдэнд тулгарсан асуудлаар хууль зүй зөвлөгөө тогтмол өгдөг сонин бол “Зууны мэдээ” юм. Ингэхдээ Эрх зүйн боловсрол Академи болон Ханс Зайдлын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтарч ажилладаг ба энэ Академийн хуульчид Та бүхэнд зөвлөгөө өгнө. Иргэдийн тавьж болох асуултын хүрээ нь эрх зүйн бүх салбарыг хамарсан нийтлэг асуудал байж болно.

**Иргэд уг сониноор дамжуулан хууль зүйн зөвлөгөө авахдаа**

1. Өөрийн сонирхож байгаа болон тулгарч буй асуудлаа асуулт хэлбэрээр “Зууны мэдээ” сонинд ирүүлнэ.

*Утас: 327-882, 9919-7393*

2. “Зууны мэдээ” сонинихон иргэдээс тавьсан асуултуудыг цуглуулан Эрх зүйн боловсролын Академид өгнө.
3. Эрх зүйн боловсролын Академийн хуульчид иргэдийн тавьсан асуултуудыг судлан үзэж, хариулт бэлтгэн, “Зууны мэдээ” сонинд илгээнэ.
4. “Зууны мэдээ” сонин 7 хоног бүр өөрийн хавсралт сонин болох “24 цаг” сониндоо хуульчдын хариултыг хэвлэх замаар иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгнө.

Мөн “Оддын амьдрал” сонин та бүхэнд зориулан хууль зүйн булан ажиллуулж байна. Хууль зүйн ямар зөвлөгөө хэрэгтэй байгаа талаар 310524 дугаарын утсаар МУИС-ХЗС-ийн Хууль зүйн Клиник сургалтын төвд дамжуулна. Тэд танд хэрэгтэй байгаа мэдээллийг уг сониноор дамжуулан хүргэнэ.